



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЖДҮГ НЬ ЖДҮҮ ЭРХЛЭГЧ НАРТ САНГААС ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙГ ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ ОЛГОЖ ЧАДААГҮЙ, ХААК ТӨХХК-ИАС ХАА-Н ДЭМЖЛЭГ АВСАН 6387 ЗЭЭЛДЭГЧ БҮЮУ 78.7 ХУВЬ НЬ 6-ААС ДЭЭШ ЖИЛЭЭР ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ, ЗБДС НЬ ХХААХҮЯ-НЫ ЭРХЛЭХ АСУУДАЛД ХАМААРАХГҮЙ ЗАРИМ САЛБАРУУДЫН ЗЭЭЛД ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТ ГАРГАЖ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДАЛД ХАМААРАХ ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГУУД БОЛОН “ХӨДӨӨ, АЖ АХУЙН КОРПОРАЦИ” ТӨХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГАГ-2025/17-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд

Утас: 263755 Цахим хаяг: enkboldd@audit.gov.mn

Аудитын менежер Д.Баттулга

Утас: 261639, Цахим хаяг: battulgad@audit.gov.mn

Ахлах аудитор З.Мөнхбаяр

Цахим хаяг: munkhbayarz@audit.gov.mn

Аудитор Т.Төмөрбаатар

Цахим хаяг: tumurbaatar@audit.gov.mn

Аудитор Т.Шүрэнцэцэг

Цахим хаяг: shurentstetsegt@audit.gov.mn

Аудитор Л.Номин

Цахим хаяг: nominl@audit.gov.mn

Аудитор А.Тэргэл

Цахим хаяг: tergela@audit.gov.mn



Улаанбаатар хот
2025 он

Монгол улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: +976 51-261585. Факс: +976 11-323266, 11-324853
И-мэйл: info@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын тусгай сангууд болон “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагаа, үр дүнд хийсэн гүйцэтгэл-нийцлийн аудитын тайлан болон аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК, Зээлийн батлан даалтын санд тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Цогтсаран, Зээлийн батлан даалтын сангийн Гүйцэтгэх захирал С.Цогтсайхан нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар (Ч.Цэвэгдорж)-т даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын багт үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчил хариуцах		Албан шаардлагын товч утга	Албан шаардлагын дүн (төгрөгөөр)
	Байгууллага	Албан тушаалтан		
1	Жижиг, дунд үйлдвэрийн газар	Газрын дарга Я.Эрдэнэсайхан	Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдэгдлээс хугацаа хэтэрсэн 214 иргэн, ААН-ийн 4,865,372,509.58 /Дөрвөн тэрбум найман зуун жаран таван сая гурван зуун далан хоёр мянга таван зуун есөн төгрөг тавин найман мөнгө/-ний зээлийг эргэн төлүүлэх.	4,865,372,509.58
2	Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК	Захирал Б.Цогтсаран	Хөдөө аж ахуйг дэмжих чиглэлээр олгосон шууд зээлийн 8110 харилцагчийн 140,627,836,884.98 (Нэг зуун дөчин тэрбум зургаан зуун хорин долоон сая найман зуун гучин зургаан мянга найман зуун наян дөрвөн төгрөг ерэн найман мөнгө)-ний зээлийн гэрээний хугацаа хэтэрсэн зөрчил арилгах.	140,627,836,884.98
3	Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК	Захирал Б.Цогтсаран	"Хөдөө, аж ахуйн корпораци" ТӨХХК нь 63 байгууллагаас 3,094,118,366.10 (гурван тэрбум ерэн дөрвөн сая нэг зуун арван найман мянга гурван зуун жаран зургаан төгрөг арван мөнгө)-ний авлагыг 2024 оны санхүүгийн жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулах.	3,094,118,366.10
4	Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК	Захирал Б.Цогтсаран	Тус байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 37 иргэн, ААН байгууллагад өгөх өглөгийн 12,277,129.80 (Арван хоёр сая хоёр зуун далан долоон мянга нэг зуун хорин есөн төгрөг наян мөнгө)-ийг авлагаар бүртгэж тайлагнасан зөрчил арилгах	12,277,129.80
	Нийт дүн			148,599,604,890.46

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
Хүснэгтийн жагсаалт	4
Дүрслэлийн жагсаалт	5
Хавсралтын жагсаалт	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	6-7
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	8
БҮЛЭГ 1. ЖДҮХ САНГААС ОЛГОСОН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН 107.4 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ АВСАН ИРГЭН, ААН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНД ЗААСАН ҮҮРГЭЭ ХАНГАЛТГҮЙ БИЕЛҮҮЛСЭН БАЙНА	9
1.1 ЖДҮГ-ын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин зэргийг тусгаагүй байна	9
1.2 ХХААХҮ-ийн сайдын ЖДҮХ сангаас хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөлийг батлахдаа тухайн жилийн зээлийн хүү, үндсэн төлбөрөөс чөлөөлөх болон зээлийн хугацааг тогтоосон тооцоолол тодорхойгүй байна	9
1.3 ЖДҮХ сангийн 2023-2024 оны эх үүсвэрийн 91 хувийг зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлогоос бүрдүүлж байна	12
1.4 ЖДҮҮ эрхлэгчдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн чиглэлээр төрийн дэмжлэг хангалтгүй байна	12
1.5 Холбогдох журмын дагуу арилжааны банкаар дамжуулан жижиг болон дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгоогүй байна	13
1.6 Зарим ААН-ийн төслийн баримт материалыг холбогдох журамд заасан шалгуурын дагуу нягтлан үзэхгүйгээр сонгон шалгаруулсан нь тухайн төсөл бүрэн хэрэгжихгүй байх зээлийн эргэн төлөлтөд эрсдэл үүсэх нөхцөл бүрдүүлсэн байна	15
1.7 Зарим ЖДҮҮ эрхлэгч нарын үйл ажиллагааны чиглэл, дадлага туршлагыг бүрэн нягтлахгүй хэрэгжүүлэхээр ирүүлсэн төслөөс өөр чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ААН-д хөнгөлөлттэй зээл олгосон байна	16
1.8 ЖДҮХ сангийн нийт зээлийн үлдэгдлийн 57.7 хувь нь хугацаа хэтэрсэн байна	17
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	19
БҮЛЭГ 2. УЛААН БУУДАЙН БОЛОН БАГА ОВРЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ОЛГОСОН ДЭМЖЛЭГЭЭС 140,627.8 САЯ ТӨГРӨГ БУЮУ 80.4 ХУВЬ НЬ ГЭРЭЭНД ЗААСАН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ БАЙНА	20
2.1 “ХААК” ТӨХХК-ийн ТУЗ бизнес төлөвлөгөөнд зорилтот түвшнийг бодитой тооцож төлөвлөөгүй байна	20
2.2 Хөдөө аж ахуйн чиглэлээр олгосон дэмжлэгийн 80.4 хувь нь гэрээний хугацаа хэтэрсэн байна	22
2.3 Монголбанкны зээлийн мэдээллийн санд ХАА-н дэмжлэгээр олгосон зээлийн зарим мэдээллийг оруулаагүй байна	23
2.4 ХАА-н дэмжлэг авсан 6387 зээлдэгч 78.7 хувь нь 6-аас дээш жилээр зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй байна	24
2.5 Хөөн хэлэлцэх хугацаа дууссан 8,425.0 сая төгрөгийн 94 зээлдэгчтэй 2024 онд шинээр гэрээ байгуулж хугацааг сэргээж ажилласан байна	24
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	26
БҮЛЭГ 3. ЗБДС 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР 14,032 ЗЭЭЛДЭГЧИД 402,577.9 САЯ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛД БАТЛАН ДААЛТ ГАРГАСАН БАЙНА	27
3.1 ЗБДС-ийн Удирдах зөвлөлийн баталсан зарим журмуудыг хууль зүйн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад хянуулаагүй байна	27
3.2 ЗБДС-ийн нийт батлан даалтын 72.1 хувийг Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн батлан даалт эзэлж байна	27
3.3 ЗБДС-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-т сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр тусгасан ба нийт орлогын 91.5 хувийг хадгаламжийн хүүгийн орлого эзэлж байна	28
3.4 СЗХ-ноос ЗБДС-ийн үйл ажиллагаанд 2023, 2024 онд хяналт, шалгалт хийгээгүй байна	29
3.5 Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 665 зээлдэгчид 200,1 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна	29
ДҮГНЭЛТ	32-33
ЗӨВЛӨМЖ	34
Холбогдох байгууллагын санал	35-40
Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар	41
Хавсралтууд	42-49

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
АХБ	Азийн хөгжлийн банк
БНБУ	Бүгд Найрамдах Беларусь Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗБДСТХ	Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль
ЗГ	Засгийн газар
ЗГТСТХ	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ЖДҮГ	Жижиг, дунд үйлдвэрийн газар
ЖДҮҮ	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ
ЖДҮҮДТХ	Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хууль
ЖДҮХ	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх
МАОЭНХ	Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
МҮХАҮТ	Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
СБХ	Санхүүгийн бодлогын хэлтэс
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СХААБГ	Санхүү, худалдан авах ажиллагааны бодлогын газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБСТЗГ	Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, зохицуулалтын газар
ХАА	Хөдөө аж ахуй
“ХААК” ТӨХХК	“Хөдөө аж ахуйн корпораци” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХТАХ	Хууль, тусгай активын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ЖДҮХ сангийн зээлийн үлдэгдэл (2023, 2024)	8
Хүснэгт 2	ЖДҮҮ эрхлэгчдийн ангилал	9
Хүснэгт 3	ХХААХҮ-ийн сайдын хөнгөлөлттэй зээл олгох ерөнхий нөхцөл баталсан тушаал	10
Хүснэгт 4	ЖДҮХС-аар дамжуулан олгосон төсөл хөтөлбөрийн зээлийн нөхцөл	10
Хүснэгт 5	Япон, Солонгос, Монгол Улсад ЖДҮҮ эрхлэгчдэд төрөөс олгож байгаа хөнгөлөлттэй зээлийн нөхцөл	11
Хүснэгт 6	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2023, 2024 оны эх үүсвэрийн мэдээлэл	12
Хүснэгт 7	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2023, 2024 оны зарцуулалтын мэдээлэл	12
Хүснэгт 8	Төрийн дэмжлэгийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ	13
Хүснэгт 9	ЖДҮХ сангаас 2023, 2024 онд нийт зээл авсан ААН-үүдийн тоо, зээлийн хэмжээ	14
Хүснэгт 10	Салбарын ангиллаар зээл олголтын байдал	15
Хүснэгт 11	Ерөнхий нөхцөлийн ангиллын бус олгосон зээлийн мэдээлэл	16
Хүснэгт 12	Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй идэвхтэй зээлийн мэдээлэл (2009-2024 он)	17
Хүснэгт 13	Хугацаа хэтэрсэн зээлүүдийн эргэн төлөлтийн мэдээлэл (хувиар)	17
Хүснэгт 14	Бизнес төлөвлөгөөний төлөвлөгөө, гүйцэтгэл	20-21
Хүснэгт 15	“ХААК” ТӨХХК-ийн урт хугацаат зээлийн үлдэгдэл	21
Хүснэгт 16	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл	21
Хүснэгт 17	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан хэлбэр	22
Хүснэгт 18	“ХААК” ТӨХХК-ийн Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	22
Хүснэгт 19	Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй идэвхтэй зээлийн мэдээлэл (ангилал бүрээр)	23
Хүснэгт 20	ХАА-г дэмжих чиглэлээр олгосон хугацаа хэтэрсэн зээлүүдийн мэдээлэл	24
Хүснэгт 21	Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл (2-10 удаа)	24
Хүснэгт 22	Өмгөөллийн нөхөрлөлийн хариуцсан авлага, түүний гүйцэтгэл (2024 оны жилийн эцсийн байдлаар)	25
Хүснэгт 23	Батлан даалгуулсан зээлдэгчийн тоо болон хөрөнгийн хэмжээ	27
Хүснэгт 24	Өөрийн хөрөнгийн бүрдүүлэлтийн байдал	28
Хүснэгт 25	ЗБДС-ийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл	28
Хүснэгт 26	АХБ-ны санхүүжилтээр 2017-2024 онд гаргасан батлан даалтын хэмжээ	30
Хүснэгт 27	Хадгаламжийн үлдэгдэлд бодогдсон хүү	30
Хүснэгт 28	БНСУ, Япон, Киргиз улсуудын ЗБДС-ийн үйл ажиллагааны талаар	31

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хүү болон инфляцын түвшнийг 2021-2025 оноор харьцуулсан үзүүлэлт	11
Дүрслэл 2	ЖДҮХ сангаас зээл олгох төсөл сонгон шалгаруулалтын үйл явц	14
Дүрслэл 3	ЖДҮХ сангаас 2023, 2024 онд аймаг, нийслэлд олгосон нийт төслийн тоо, зээлийн хэмжээ	15
Дүрслэл 4	ЗБДС-аас иргэн, ААН-д батлан даалт гаргах үйл явц	26

Хавсралтын жагсаалт

Дугаар	Агуулга
Хавсралт 1	Аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны чиглэл нь зээлийн ерөнхий нөхцөлд тусгасан салбар, чиглэлтэй нийцэхгүй жагсаалт
Хавсралт 2	Хөнгөлөлттэй зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй 5-16 жилээр хугацаа хэтэрсэн зээлдэгчдийн жагсаалт
Хавсралт 3	Зээлийг эргэн төлүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай зээлүүдийн жагсаалт
Хавсралт 4	“ХААК” ТӨХХК-ийн дэмжлэгийн бус зээлийн мэдээлэл
Хавсралт 5	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон зээлийн батлан даалт гаргасан байдал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалыг үндэслэн “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын тусгай сангууд болон “Хөдөө, аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагаа, үр дүн” сэдэвт аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын тусгай сангууд болон “Хөдөө, аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагаа, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- *Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрхлэх асуудалд хамаарах Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт үр дүнтэй эсэх;*
- *“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагаа, үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;*
- *Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа, хэрэгжилт, зарцуулалт үр дүнтэй эсэх;*

Аудитын хамарсан хүрээ

Аудитад шалгагдагч байгууллагаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК, Зээлийн батлан даалтын сан болон тус газруудаас 2023, 2024 онд зээл авсан иргэн, ААН болон бусад холбогдох байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг аудитын арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- *Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;*
- *Захиргааны ерөнхий хууль;*
- *Төрийн аудитын тухай хууль;*
- *Төсвийн тухай хууль;*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;*
- *Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;*
- *Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;*
- *Зээлийн мэдээллийн тухай хууль;*
- *Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хууль;*
- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;*
- *Холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бодлогын баримт бичиг, стандарт;*
- *УИХ-ын болон ЗГ-ын холбогдох тогтоол, шийдвэрүүд.*

Аудитын багийн бүрэлдэхүүн

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Баттулга хэрэгжүүлж, ахлах аудитор З.Мөнхбаяр, аудитор Т.Төмөрбаатар, Т.Шүрэнцэцэг, А.Тэргэл, Л.Номин нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т “*Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зориулалттай байна.*”, Мөн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “*Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан /цаашид "Сан" гэх/ байна*” гэж тус тус заасан байна.

ЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийн газар” /цаашид “ЖДҮГ” гэх/-ыг байгуулан ЖДҮХ сангийн ажлын албыг татан буулгаж, холбогдох чиг үүрэг, орон тоо, үйл ажиллагааны зардал, эд хөрөнгийн хамт ЖДҮГ-т шилжүүлсэн байна.

ЖДҮХ сангаас 2009-2024 онд нийт 370,110.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1747 иргэн, ААН-д олгосон байна. Үүнээс 184,081.6 сая төгрөгийн зээлийг 508 зээлдэгч буюу 49.7 хувь нь хугацаандаа эргэн төлсөн. Харин үлдсэн 1239 зээлдэгч буюу 50.3 хувь нь хугацаандаа төлөөгүйгээс бодит зээлийн үлдэгдэл 186,028.6 сая төгрөг байна.

ЖДҮХ сангаас 2009-2024 онд 370,110.2 сая төгрөгийн зээл олгосноос 50.3 хувь буюу 186,028.6 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 78,641.3 сая төгрөг буюу 42.3 хувь нь хэвийн, 3,270.1 сая төгрөг буюу 1.8 хувь нь хэвийн бус, 2,722.5 сая төгрөг буюу 1.5 хувь нь эргэлзээтэй, 4,574.7 сая төгрөг буюу 2.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 96,820.1 сая төгрөг буюу 52.0 хувь нь муу ангилалд бүртгэгдсэн байна.

Хүснэгт 1. ЖДҮХ сангийн зээлийн үлдэгдэл (2023, 2024)

Д/д	Он	Эхний үлдэгдэл	Олгосон	/сая.төг/	
				Эцсийн үлдэгдэл	
1	2023	165,337.9	35,436.4	172,551.4	
2	2024	172,551.4	38,606.5	186,028.6	

Эх сурвалж: ЖДҮХ сангийн 2023, 2024 оны санхүүгийн тайлан

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн ЖДҮҮ эрхлэгчид олгосон зээлийн авлагын үлдэгдэл өмнөх оноос 13,477.2 сая төгрөгөөр буюу 7.2 хувиар өссөн байна.

БҮЛЭГ 1. ЖДҮХ САНГААС ОЛГОСОН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН 107.4 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛ АВСАН ИРГЭН, ААН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНД ЗААСАН ҮҮРГЭЭ ХАНГАЛТГҮЙ БИЕЛҮҮЛСЭН БАЙНА.

1.1 ЖДҮГ-ын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин зэргийг тусгаагүй байна.

1.1.1 Засгийн газрын тусгай сангийн хууль /цаашид ЗГТСтХ гэх/-ийн 4 дүгээр зүйлийн 1.1.1-т “Засгийн газрын тусгай сан” гэж Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай төсвийн тусгай дансыг”, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.5-т “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан” нь ЗГ-ын тусгай сангийн төрөлд хамаарч байна.

1.1.2 ЖДҮХ сангийн үйл ажиллагааг ЖДҮҮДтХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “сангийн хуульд заасан чиг үүргийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

1.1.3 УИХ-аас Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийг 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдөр баталж, 2 удаа шинэчилсэн найруулга хийж, 4 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

1.1.4 Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Дараах нөхцөлийг хангасан аж ахуйн нэгжийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хамааруулна” гэж тусгасан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. ЖДҮҮ эрхлэгчдийн ангилал

Ангилал	Ажилтны тоо	Борлуулалтын орлогын хэмжээ	Зээл олгох хэмжээ
Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	10 хүртэл	0-300.0 сая	300.0 сая төгрөг хүртэл
Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	10-50 хүртэл	300.0-1,000.0 сая	1,000.0 сая төгрөг хүртэл
Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	50-200 хүртэл	1,000.0-2,500.0 сая	2,500.0 сая төгрөг хүртэл

1.1.5 ЖДҮҮДтХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.7-д “Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид зээлийг сангаас шууд, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид банкаар дамжуулж олгоно. Банкныг сонгон шалгаруулалтаар сонгоно. Банканд сангийн эх үүсвэрийг байршуулах, зээл олгох журмыг Засгийн газар батална” гэж заасан байна.

1.1.6 ЖДҮҮДтХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.7¹, ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д ЖДҮХ сангийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж байна.

1.1.7 ЖДҮГ нь стратеги төлөвлөгөөгүй үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1², ЗГ-ын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.1³ дэх заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна. Аудитаар холбогдох байгууллагад стратеги төлөвлөгөөг батлуулах зөвлөмж хүргүүлэв.

1.2 ХХААХҮ-ийн сайдын ЖДҮХ сангаас хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөлийг батлахдаа тухайн жилийн зээлийн хүү, үндсэн төлбөрөөс чөлөөлөх болон зээлийн хугацааг тогтоосон тооцоолол тодорхойгүй байна.

¹ 11.7. Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид зээлийг Сангаас шууд, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид банкаар дамжуулж олгоно. Банкныг сонгон шалгаруулалтаар сонгоно. Банканд Сангийн эх үүсвэрийг байршуулах, зээл олгох журмыг Засгийн газар батална.

² 53.1.Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

³ 2.1. Стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд арга хэмжээний төлөвлөгөө батлагдсанаас хойш хоёр сарын дотор салбарын, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн, байгууллагын стратеги төлөвлөгөөг тус тус дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулна.

1.2.1 3Г-ын 2020 оны 113 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4⁴-т заасны дагуу ХХААХҮ-ийн сайдын 2023 оны А/37, 2024 оны А/28 дугаар тушаалаар ерөнхий нөхцөлийг баталсан нь зээлийн жилийн хүү, үндсэн төлбөрөөс чөлөөлөх болон зээлийн хугацааг баталсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. ХХААХҮ-ийн сайдын хөнгөлөлттэй зээл олгох ерөнхий нөхцөл баталсан тушаал

/сая.төг/						
Он	Тушаалын дугаар, нэр	Салбар	Зээлийн хүү /жилийн/	Зээлийн хугацаа	Төлбөрөөс чөлөөлөх хугацаа	Олгох зээлийн дүн
2023	ХХААХҮ-ийн сайдын А/37 “Ерөнхий нөхцөл батлах”	Хүнсний үйлдвэр	3%	5 хүртэл жил	12 сар хүртэл	28,400.1
		Газар тариалан				
		Хөнгөн үйлдвэр				
		Мал аж ахуй				
2024	ХХААХҮ-ийн сайдын А/28 “Ерөнхий нөхцөл батлах”	Хүнсний үйлдвэр	3%	5 хүртэл жил	12 сар хүртэл	29,000.0
		Газар тариалан				
		Мал аж ахуй				
		Хөнгөн үйлдвэр				
		Үйлчилгээ				

1.2.2 ХХААХҮ-ийн сайд 2023-2024 онд дараах чиглэлээр “Хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай” тушаалаар ЖДҮХ сангаар дамжуулан олгох салбар чиглэлийг баталсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. ЖДҮХ сангаар дамжуулан олгосон төсөл, хөтөлбөрийн зээлийн нөхцөл

/сая.төг/						
№	Он	ХХААХҮ-ийн сайдын тушаалын дугаар, нэр	Зээлийн хүү /жилийн/	Зээлийн хугацаа	Төлбөрөөс чөлөөлөх хугацаа	Олгох зээлийн дүн
1	2023	А/326 дугаар “Зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай”	3%	8 хүртэл жил	3 жил хүртэл	4,700.0
		А/554 дугаар “Хөдөө аж ахуйн Загвар хоршоонд хөнгөлөлттэй зээл олгох ерөнхий нөхцөл батлах тухай”	5%	5 хүртэл жил	1 жил хүртэл	3,200.0
2	2024	А/26 дугаар “Хөдөө аж ахуйн Загвар хоршооны зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай”	5%	5 хүртэл жил	1 жил хүртэл	4,200.0
		А/27 дугаар “Жимс, жимсгэнийн төрөлжсөн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай”	3%	8 хүртэл жил	3 жил хүртэл	2,850.0
		А/205 дугаар “Хөрөнгийг шилжүүлэх, Зөгийн аж ахуйн кластер байгуулах зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай”	3%	5 хүртэл жил	1 жил хүртэл	270.0

1.2.3 ЖДҮХ сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөлийг батлахдаа дараах хөтөлбөр, зорилтуудыг үндэслэсэн байна. Үүнд,

- “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.13-т “Жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн бодлого хэрэгжүүлэх”;

⁴ “Хууль тогтоомж болон Засгийн газрын бодлого, төсөл хөтөлбөртэй уялдуулан, зээл олгох салбар, чиглэл, зээлийн хугацаа, хүү, эх үүсвэрийн багцын хуваарилалт зэргийг зээл олгоход шаардлагатай бусад нөхцөл, шаардлагыг (Ерөнхий нөхцөл)-ийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.


- “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, хот, хөдөөгийн сэрэгэлтийн чиглэлээр орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих;
- УИХ-аас 2022 онд баталсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолоор ирэх 5 жил гол нэрийн 19 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах зорилтыг хэрэгжүүлэх;
- Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой усны нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих;

1.2.4 Монгол Улсыг хөгжүүлэх урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт ЖДҮҮ-г хөгжүүлэх чиглэлээр тусгасан дээрх арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

1.2.5 ЖДҮХ сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн жилийн хүү, хугацаа, үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа зэргийг тогтоохдоо эдийн засгийн тооцоолол, зах зээлийн судалгаа хийгээгүй, 2009 оноос хойш зээлийн хүү, хугацаанд өөрчлөлт оруулаагүй байна.

1.2.6 Инфляцын түвшин, арилжааны банкны бизнесийн зээлийн дундаж хүү, ЖДҮХ сангийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн харьцуулалтыг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 1. Хүү болон инфляцын түвшнийг харьцуулсан үзүүлэлт /2021-2025 он/



Эх сурвалж: УЦХ, Арилжааны банк

1.2.7 Дээрх дүрслэлээс үзэхэд төрөөс ЖДҮҮ эрхлэгчдийг дэмжих зорилгоор сүүлийн 5 жилийн инфляцын түвшнээс бага буюу жилийн 3 хувийн хүүтэй зээл олгож байна.

1.2.8 Бусад улсад ЖДҮҮ-г санхүүжүүлэх аргуудыг эдийн засгийн онцлог, төрийн бодлого, ЖДҮҮ эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагаас шалтгаалан зээлийн хэмжээ, хүүгийн хувь, зээлийн эргэн төлөх хугацаа нь харилцан адилгүй байна. Азийн зарим улстай Монгол Улсын ЖДҮҮ эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлийг харьцуулбал:

Хүснэгт 5. ЖДҮҮ эрхлэгчдэд олгож буй хөнгөлөлттэй зээлийн судалгаа

№	Улс	Хэрэгжүүлэгч байгууллага	Зээлийн хэмжээ		Зээлийн хүү /хувь/	Зээлийн хугацаа /жил/
1	Япон Улс	Japan Finance Corporation (JFC) ЖДҮ-ийн зээл	50.0 сая.иен	300.0-400.0 сая.usd	1.0–2.0	5–15
2	БНСУ	Korea SMEs and Startups Agency (KOSME) зээл	500.0 сая. вон	370.0 сая. usd	1.5–3.0	5–10
3	Монгол Улс	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан (ЖДҮХС) зээл	300.0-2,500.0 сая төгрөг	-	3.0–8.0	3–5

Эх сурвалж: JFC, KOSME

1.2.9 Тухайлбал Япон, БНСУ нь ЖДҮҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгохдоо санхүүгийн чадавх (орлого, ашиг, өр төлбөр), компанийн түүх, итгэлцэл, бизнесийн төлөвлөгөө, инновац, технологийн түвшин зэргийг харгалзан үздэг байна.

1.2.10 Монгол Улсын хувьд ЖДҮХ сангаас олгож буй хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөх хугацааг хөгжиж буй зарим улстай харьцуулахад харьцангуй богино байгаа нь төсөл үр

дүнтэй хэрэгжиж ЖДҮҮ хөгжих, улмаар ААН-үүдийн үйл ажиллагаа тогтворжих бодит дэмжлэг үзүүлж чадахааргүй байна.

1.3 ЖДҮХ сангийн 2023-2024 оны эх үүсвэрийн 91 хувийг зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлогоос бүрдүүлж байна.

1.3.1 ЖДҮХ сангийн санхүүжилтэд “Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төсөл”-д 204,000.0 сая төгрөг, “Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөл”-д 113,002.0 сая төгрөгийн санал өгсөн боловч Улсын төсвийн хөрөнгийг батлаагүй байна. “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-тэй холбоотойгоор 1,462.9 сая төгрөгийг 2024 онд улсын төсөвт батлагдсан байна.

Хүснэгт 6. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2023, 2024 оны эх үүсвэрийн мэдээлэл

№	Эх үүсвэр	/сая.төг/	
		2023 он	2024 он
1	Улсын төсвийн хөрөнгө	-	1,463.0
2	Зээлийн эргэн төлөлт	45,546.1	48,954.0
3	Зээлийн хүүгийн орлого	3,017.6	2,694.8
4	Орон нутгийн төсвийн санхүүжилт	5,800.0	4,200.0
Нийт		54,363.7	57,311.8

1.3.2 ЖДҮХ санд орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох зохицуулалтыг ЖДҮҮДТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.4⁵-т заасны дагуу дараах аймгуудаас 2023 онд 5,800.0 сая төгрөг, 2024 онд 4,200.0 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. Үүнд:

- **2023 онд** Өмнөговь аймаг 5,000.0 сая, Дархан-Уул аймаг 500.0 сая, Сүхбаатар аймаг 300.0 сая төгрөг;
- **2024 онд** Өмнөговь аймаг 3,000.0 сая, Завхан аймаг 500.0 сая, Орхон аймаг 400.0 сая, Сүхбаатар аймаг 300.0 сая төгрөг

1.3.3 ЗГТСтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.6⁶-д заасны дагуу зарцуулдаг бөгөөд ЖДҮХ сангийн 2023-2024 оны зарцуулалтын мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2023, 2024 оны зарцуулалтын мэдээлэл

№	Үзүүлэлт	/сая.төг/	
		2023 он	2024 он
1	ЖДҮГ-ын үйл ажиллагааны зардалд	2,438.5	2,536.2
2	Хөнгөлөлттэй зээлд олгосон хэмжээ	35,628.8	39,486.9
3	Харилцах дансны үлдэгдэл	16,296.4	15,287.7
Нийт зардал		54,363.7	57,310.8

Эх үүсвэр: ЖДҮГ

1.3.4 Төвлөрүүлсэн төсвөөс 2023 онд 65.5 хувь, 2024 онд 68.9 хувийг хөнгөлөлттэй зээлд олгож байна.

1.3.5 ЖДҮХ сангаас 2023-2024 онд 4,974.7 сая төгрөгийн санхүүжилтийг ЖДҮГ-ын үйл ажиллагаанд зарцуулсан нь ЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор ЖДҮХ сангийн ажлын албыг татан буулгаж, холбогдох албан хаагчдыг чиг үүрэг, орон тоо, үйл ажиллагааны зардал, цалингийн сан, эд хөрөнгийн хамт ЖДҮГ-т шилжүүлсэнтэй холбоотой байна.

1.4 ЖДҮҮ эрхлэгчдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн чиглэлээр төрийн дэмжлэг хангалтгүй байна.

1.4.1 ЖДҮҮДТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цар хүрээ, хөгжлийн үе шат, бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө, гадаад зах зээлд нэвтрэх чадамж, техник, технологийн байдлыг нь харгалзан төрөөс дэмжлэг үзүүлнэ” гэж заасны дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

⁵ “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд орон нутгийн төсвөөс хөрөнгө олгож болох бөгөөд түүний хэмжээг аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална”
⁶ 6.6.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна

Хүснэгт 8. Төрийн дэмжлэгийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Дэмжлэгийн чиглэл	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	ЖДҮҮ эрхлэгчдийн тоо	
			2023 он	2024 он
1	Бизнесийн зөвлөх үйлчилгээ, үзүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх	Танхимын болон цахим сургалт 27 удаа зохион байгуулсан	8250	1925
2	Санхүүгийн дэмжлэг үзүүлэх	ЖДҮХ сангаас хөнгөлөлттэй зээл олгосон	265	280
3	Дотоодын зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх	Үзэсгэлэн худалдаа 16 удаа зохион байгуулсан	550	100
4	Кластер ба инновацыг хөгжүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх дэмжлэг	Онол практикийн бага хурал 1 удаа, хэлэлцүүлэг, форум 5 удаа зохион байгуулсан	150	280
5	Гадаадын зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх үзүүлэх	Гадаадын 8 улсад 13 удаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан	450	170

Эх сурвалж: ЖДҮГ

1.4.2 ЖДҮҮДТХ-ийн 8 дугаар зүйлд төрөөс ЖДҮҮ-г дэмжих талаар баримтлах бодлогын чиглэлүүдээс татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх судалгааг дэмжих чиглэлийн арга хэмжээг авч ажиллаагүй байна.

1.4.3 ЖДҮХ сангаас хөнгөлөлттэй зээл авсан 158 ЖДҮҮ эрхлэгчээс санал асуулга авахад дараах байдлаар хариуллаа. Үүнд:

- ЖДҮХ сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөх хугацааг 5-10 жил болгох талаар 49.7 хувь;
- ЖДҮХ сангаас олгосон зээлийг “Тоног төхөөрөмжөө шинэчлэх”-дээ зарцуулсан талаар 76.9 хувь;
- Төрөөс ЖДҮҮ эрхлэгчдэд үзүүлж буй бодлогын дэмжлэг “Хангалтгүй” байгаа талаар 51 хувь;
- Төрөөс “Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх” шаардлагатай байгаа талаар 51 хувь;
- ЖДҮХ сангийн хөнгөлөлттэй зээл авсан ААН-үүд төслөө хэрэгжүүлэхэд “Үнийн өсөлт” нөлөөлж буй талаар 58.7 хувь;
- ААН-үүдэд ЖДҮХ сангаас зээл олгоход тавьж буй шаардлагуудаас “Барьцаа хөрөнгийг хэт доогуур үнэлдэгтэй санал нийлэхгүй байна” гэж 43.2 хувь нь тус тус хариулсан байна.

1.4.4 Санал асуулгад оролцсон ЖДҮҮ эрхлэгчид хэрэгжүүлж байгаа төслөөс хамаарч хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөх хугацааг 5-10 жил болгон нэмэгдүүлэх, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг хангалтгүй буюу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх дэмжлэг шаардлагатай гэсэн үр дүн гарсан байна.

1.5 Холбогдох журмын дагуу арилжааны банкаар дамжуулан жижиг болон дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгоогүй байна.

1.5.1 ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.1⁷-д сангаас шууд болон арилжааны банкаар дамжуулан ЖДҮҮ эрхлэгчдэд зээл олгохоор зохицуулсан байна.

1.5.2 Дээрх журмын 11 дүгээр зүйлийн 11.3-т сангаас шууд олгох зээлийн төсөл сонгон шалгаруулалтыг дараах 4 үе шаттайгаар үнэлгээ хийхээр заасан байна. Үүнд:

- Төслийн иж бүрдлийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ажлын хэсэг шалгах ба иж бүрдлийг бүрэн хангасан төслийг дараагийн шатанд шилжүүлэх;

⁷ 3.1. Зээлийг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11.7-д заасны дагуу Сангаас шууд болон арилжааны банкаар дамжуулан олгоно.

- Төслийн урьдчилсан судалгааг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэн хийж, 100 хүртэл оноогоор дүгнэх ба 70-аас дээш оноо авсан төслийг дараагийн шатанд шилжүүлэх;
- Төсөлд нарийвчилсан судалгааг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нарийвчилсан судалгааны ажлын хэсэг хийж, 100 хүртэл оноогоор дүгнэх ба 70-аас дээш оноо авсан төслийг дараагийн шатанд шилжүүлэх;
- Төслийг хороо, дэд хорооны хурлаар хэлэлцэж, гишүүн тус бүр 100 хүртэл оноогоор дүгнэн, дундаж оноог гаргах.

1.5.3 Тус журмын 10 дугаар зүйлийн 10.5-д⁸ гэж заасан боловч төсөл хүлээн авснаас хойш сонгон шалгаруулалтын үе шатны үнэлгээ хийх нарийвчилсан хугацааг тусгаагүй байна.

1.5.4 ЖДҮГ-ын даргын 2023 оны А/20, 2024 оны А/30 дугаартай “Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” тушаалаар байгуулсан ажлын хэсэг нь сангаас хөнгөлөлттэй зээлийн хүсэлт ирүүлсэн ААН-үүдийн ирүүлсэн төслийн иж бүрдэл болон анхан шатны шалгуур хангасан эсэхэд үнэлгээ хийсэн байна.

1.5.5 Төсөл сонгон шалгаруулах Хороо, дэд хороо нь дарга, гишүүд, нарийн бичгийн дарга болон төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 7 гишүүний бүрэлдэхүүнтэй дараах эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулахаар зохицуулсан байна. Үүнд:

- Хороо нь жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын судалсан төслийг хуралдаанаар хэлэлцэх, сонгон шалгаруулах, холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дагуу шийдвэр гаргах эрхтэй.
- Дэд хороо нь жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн мэргэжилтний судалсан төслийг хуралдаанаар хэлэлцэх, сонгон шалгаруулах, холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дагуу шийдвэр гаргах эрхтэй.

Дүрслэл 2. ЖДҮХ сангаас зээл олгох төсөл сонгон шалгаруулалтын үйл явц



1.5.6 ЖДҮГ 2023-2024 онд нийт 545 аж ахуйн нэгжид **бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн** ангиллаар 74,042.9 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Харин жижиг болон дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд арилжааны банкаар дамжуулан зээл олгоогүй байна.

Хүснэгт 9. ЖДҮХ сангаас 2023, 2024 онд зээл авсан ААН-үүдийн талаарх мэдээлэл


/сая.төг/

Байршил	2023 он				2024 он			
	Хүсэлт ирүүлсэн	Зээл авсан	Мөнгөн дүн	Хувь	Хүсэлт ирүүлсэн	Зээл авсан	Мөнгөн дүн	Хувь
Орон нутаг	604	223	27,324.1	77.1	520	216	26,863.6	69.6
Нийслэл	216	42	8,112.3	22.9	322	64	11,742.9	30.4
Нийт	820	265	35,436.4		842	280	38,606.5	

⁸ “Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь төсөл хүлээн авах хугацааг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж, тухайн өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн хугацаанд цахимаар эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авна”

1.5.7 ЖДҮХ сангаас 2023 онд хүсэлт ирүүлсэн ААН-үүдийн 32.3 хувь, 2024 онд 33.2 хувийг шийдвэрлэж хөнгөлөлттэй зээл олгосон байна.

Дүрслэл 3. ЖДҮХ сангаас 2023, 2024 онд олгосон хөнгөлөлттэй зээлийн дүн, төслийн тоо



1.5.8 Дээрх дүрслэлээс дүгнэхэд Өмнөговь аймаг орон нутгийн төсвөөс ЖДҮХ санд 2023, 2024 онд нийт 8,000.0 сая төгрөгийг төвлөрүүлснээс 45 ААН-д 5,408.4 сая төгрөгийг олгож, ЖДҮҮ-г дэмжиж ажиллаж байна.

1.6 Зарим ААН-ийн төслийн баримт материалыг холбогдох журамд заасан шалгуурын дагуу нягтлан үзэхгүйгээр сонгон шалгаруулсан нь тухайн төсөл бүрэн хэрэгжихгүй байх зээлийн эргэн төлөлтөд эрсдэл үүсэх нөхцөл бүрдүүлсэн байна.

1.6.1 ЖДҮХ сангаас 2023, 2024 онд хөнгөлөлттэй зээл авсан нийт 545 ААН-ээс аудитын түүвэрт хамруулсан 11,221.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан 93 ААН-ийг сонгон шалгаруулсан дэд хорооны анхан шатны баримт материалыг тулган шалгахад төсөл хэрэгжүүлэхдээ өөрөөс санхүүжүүлэх хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, баримтаар нотлогдохгүй 78 ААН-д 9,046.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон алдаа зөрчил илэрлээ.

1.6.2 Аудитын түүвэрт хамруулсан ААН-үүдээс 72.6 хувь нь ЖДҮХ сангийн захирлын 2020 оны А/72 дугаар “Төслийн судалгаа үнэлгээний хүснэгтийг шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралтаар баталсан Төсөл сонгон шалгаруулах урьдчилсан судалгаа үнэлгээний маягтын шалгуур үзүүлэлтийг хангаагүй, өөрөөс санхүүжүүлэх хөрөнгө нь нотлогдохгүй байна.

1.6.3 ЖДҮХ сангаас 2023, 2024 онд хөнгөлөлттэй зээл авсан ААН-үүдийг салбарын ангиллаар авч үзэхэд 2024 онд “Үйлчилгээ”-ний салбар шинээр нэмэгдсэн байна. 2023 онд “Газар тариалан”, 2024 онд “Хүнсний үйлдвэр”-т бусад салбараас илүү хөнгөлөлттэй зээлийг олгожээ. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 10. Салбарын ангиллаар зээл олголтын байдал

/сая.төг/

№	Салбарын нэр	2023 он			2024 он		
		ААН-ийн тоо	Зээлийн дүн	Хувь	ААН-ийн тоо	Зээлийн дүн	Хувь
1	Хүнсний үйлдвэр	57	8,187.8	25.6	93	12,728.9	33.0
2	Хөнгөн үйлдвэр	45	5,390.5	15.2	62	8,812.7	22.8
3	Газар тариалан	72	10,831.2	30.6	45	6,274.1	16.2
4	Мал аж ахуй	66	8,122.3	23.9	49	6,958.4	18.0
5	Бусад	23	2,572.7	7.3	4	451.2	1.2
6	Үйлчилгээ	-	-	-	27	3,381.4	8.8
Нийт		265	35,436.4	100.0	280	38,606.7	100.0

Эх сурвалж: ЖДҮГ

1.6.4 Өмнөговь аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд хороо нь ХХААХҮ-ийн сайдын баталсан зээлийн ерөнхий нөхцөлд тусгаагүй салбаруудад 2,828.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон нь тухайн жилийн зорилтод бүрэн нийцэхгүй байна.

Хүснэгт 11. Ерөнхий нөхцөлийн ангиллын бус олгосон зээлийн мэдээлэл

/Сая.төг/

№	Салбар нэр	2023 он		2024 он	
		ААН-н тоо	Зээлийн дүн	ААН-н тоо	Зээлийн дүн
1	Аялал жуулчлал	2	182.8	-	-
2	Гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3	486.5	-	-
3	Зочид буудал	2	198.0	-	-
4	Автомашин угаалга, засвар	3	498.0	-	-
5	Хэвлэлийн үйлчилгээ	2	192.0	-	-
6	Эмнэлгийн үйлчилгээ	1	105.0	-	-
7	Барилгын засал, чимэглэл	1	98.7	-	-
8	Зоогийн газрын үйлчилгээ	1	80.0	1	99.4
9	Төмөр хийц, төмрийн дархан	1	91.0	1	98.0
10	Нийтийн халуун усны үйлчилгээ	1	80.0	-	-
11	Цайны үйлдвэрлэл	1	95.7	-	-
12	Цэвэр усны үйлдвэр	1	100.0	-	-
13	Мод, модон үйлдвэрлэл	1	100.0	-	-
14	Ажлын хувцас үйлдвэрлэл	1	70.0	-	-
15	Амралтын газар	-	-	1	154
16	Худалдааны үйлчилгээний төв	-	-	1	99.8
Бусад ангиллаар олгосон нийт дүн		21	2,377.70	4	451.2

Эх сурвалж. ЖДҮГ

1.6.5 ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д заасны дагуу ХХААХҮ-ийн сайдын тушаалаар салбар, чиглэлийг баталсан тушаалд заагаагүй салбарт хөнгөлөлттэй зээл олгосон байна.

1.7 Зарим ЖДҮҮ эрхлэгч нарын үйл ажиллагааны чиглэл, дадлага туршлагыг бүрэн нягтлахгүй хэрэгжүүлэхээр ирүүлсэн төслөөс өөр чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ААН-д хөнгөлөлттэй зээл олгосон байна.

1.7.1 ЖДҮХ сангаас 2023, 2024 онд хөнгөлөлттэй зээл авсан нийт 545 ААН-ийн төсөл сонгон шалгаруулалтын үед ирүүлсэн баримт материалаас төслөө хэрэгжүүлэх дадлага туршлагыг улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан үйл ажиллагааны чиглэлтэй тулган баталгаажуулахад 3,987.3 сая төгрөгийн зээл авсан 25 ААН-ийн үйл ажиллагааны чиглэл хэрэгжүүлэх төсөлтэй нь нийцэхгүй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 1-с үзнэ үү) Тухайлбал:

1.7.2 ЖДҮХ сангаас 2023, 2024 онд 3,987.3 сая төгрөгийн зээл авсан 25 ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан үйл ажиллагааны чиглэл хэрэгжүүлж буй төсөлтэй нь нийцээгүй байна.

- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар боловч Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр;
- Аялал жуулчлал, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар боловч Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр;
- Хэвлэлийн үйлдвэрлэл, Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйлчилгээ, Гадаад худалдаа, Программ хангамж, мэдээллийн технологийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар боловч Хүнсний зоорь, агуулах чиглэлээр;
- Хүнсний бөөний худалдаа, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар боловч Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрийн чиглэлээр;
- Гар урлал, гадаад худалдаа, барааны дэлгүүрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар боловч гар урлал, Гадаад худалдаа, Барааны дэлгүүрийн чиглэлээр;
- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа, Автомашинаар ачаа тээвэрлэх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар боловч Хүнсний зоорь, агуулах чиглэлээр тус тус зээл авсан байна.

1.7.3 ЖДҮХ сангаас хөнгөлөлттэй зээл олгохдоо ААН-үүдийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх бизнесийн тогтмол мөнгөн урсгал, дадлага туршлага болон хүний нөөцийн чадамж зэргийг харгалзан үздэггүй байна.

1.8 ЖДҮХ сангийн нийт зээлийн үлдэгдлийн 57.7 хувь нь хугацаа хэтэрсэн байна.

1.8.1 ЖДҮХ сангаас 2009-2024 оны нийт 370,110.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1747 зээлдэгчид олгожээ. Үүнээс 2024 оны жилийн эцсийн байдлаар Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2019 оны А-155/134 дүгээр тушаалын хавсралтаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1⁹-т заасан ангиллын дагуу 78,641.3 сая төгрөгийн 739 зээл хэвийн, 3,270.1 сая төгрөгийн 36 зээл хэвийн бус, 2,722.5 сая төгрөгийн 40 зээл эргэлзээтэй, 4,574.7 сая төгрөгийн 55 зээл хугацаа хэтэрсэн, 96,820.1 сая төгрөгийн 369 зээл муу ангилалд бүртгээсэн байна.

Хүснэгт 12. Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй идэвхтэй зээлийн мэдээлэл (2009-2024 он)

№	Он	Иргэн, ААН /тоо/	Үндсэн зээлийн бодит үлдэгдэл	Ангилал									
				Хэвийн /15-30 хоног/		Анхаарал хандуулах /90-аас бага хоног/		Хэвийн бус /91-180 хоног/		Эргэлзээтэй /181-360 хоног/		Муу /361-ээс дээш хоног/	
1	2009	9	192.3	-	-	-	-	-	-	-	-	9	192.4
2	2010	5	86.3	-	-	-	-	-	-	-	-	5	86.3
3	2011	18	1,046.9	-	-	-	-	-	-	-	-	18	1,046.9
4	2012	2	27.8	-	-	-	-	-	-	-	-	2	27.8
5	2013	6	4,353.8	-	-	-	-	-	-	-	-	6	4,353.8
6	2014	15	8,895.0	-	-	-	-	-	-	-	-	15	8,895.0
8	2016	22	14,379.5	-	-	-	-	-	-	-	-	22	14,379.5
9	2017	75	22,661.8	-	-	-	-	-	-	-	-	75	22,661.8
10	2018	93	31,887.0	-	-	-	-	-	-	-	-	93	31,887.0
11	2019	93	7,767.7	29	819.9	3	256.7	2	2.2	9	218.6	50	6,470.4
12	2020	192	7,501.8	101	2,475.1	17	609.2	15	540.4	16	591.0	43	3,286.1
13	2021	12	458.2	6	238.4	5	139.8					1	80.0
14	2022	154	14,941.2	107	9,676.5	10	824.8	4	402.9	11	1,245.0	22	2,792.0
15	2023	263	33,257.4	218	27,455.4	18	2,148.3	15	2,324.6	4	668.0	8	661.2
16	2024	280	38,571.9	278	37,976.0	2	596.0	-	-	-	-	-	-
Нийт		1239	186,028.6	739	78,641.3	55	4,574.7	36	3,270.1	40	2,722.5	369	96,820.1

Эх сурвалж: ЖДҮГ-Монголбанкны зээлийн мэдээллийн сан

1.8.2 ЖДҮХ сангаас 2016-2018 онд олгосон 96,820.1 сая төгрөгийн муу зээлийн үлдэгдэл буюу 71.2 хувь нь эзэлж байна. Эдгээр зээлүүдийг ЗГ-ын 2016 оны 138 дугаар “Түр журам батлах тухай” тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам”-ын дагуу хөнгөлөлттэй зээлүүдийг олгосон байна.

1.8.3 Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй идэвхтэй зээлийн бүртгэлээс харахад 107,387.3 сая төгрөгийн 500 зээл хугацаа хэтэрсэн бөгөөд эдгээрийг зээлийн эргэн төлөлт хийсэн байдлаар нь харуулбал,

Хүснэгт 13. Хугацаа хэтэрсэн зээлүүдийн эргэн төлөлтийн мэдээлэл (хувиар)

№	Эргэн төлөлт хийсэн хувь	Зээлдэгчийн тоо	Мөнгөн дүн
1	0 хувь буюу огт төлөлт хийгээгүй	119	40,757.9
2	10 хувь хүртэл	96	29,335.7
3	11-30 хувь	73	21,171.4
4	31-50 хувь	46	6,266.9
5	51-ээс дээш хувь	166	9,855.4
Нийт		500	107,387.3

⁹ 2.1.1.1.Хэвийн, 2.1.1.2.Анхаарал хандуулах; 2.1.1.3.Чанаргүй ангилал, үүнээс: 2.1.1.3.а.Хэвийн бус; 2.1.1.3.б.Эргэлзээтэй; 2.1.1.3.в.Муу.

1.8.4 Зээлийн эргэн төлөлт огт хийгээгүй зээлдэгчдээс зээлийн гэрээний хугацаа дууссан 35,246.7 сая төгрөгийн 82 зээлдэгчдийг холбогдох хууль, хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүлэв. *(Дэлгэрэнгүйг хавсралт 2-с үзнэ үү)*

1.8.5 ЖДҮХ сангаас 2009-2011 онд хөнгөлөлттэй зээл авсан 2,532.8 сая төгрөгийн 13 зээлдэгчтэй барьцааны гэрээг байгуулаагүй байна.

1.8.6 ЖДҮГ-т ажиллагаанд байгаа 91,404.2 сая төгрөгийн 296 муу зээлүүдийг төлөвөөр нь харуулбал:

- *Хуулийн хэлтэст ажиллагаа хийж байгаа 9,341.4 сая төгрөгийн 69 зээл*
- *Шүүхийн шатанд байгаа 22,001.5 сая төгрөгийн 76 зээл;*
- *Шүүхийн шийдвэр гарсан 11,241.6 сая төгрөгийн 50 зээл;*
- *ШШГГ-т шилжсэн 42,541.6 сая төгрөгийн 85 зээл;*
- *Эрэн сурвалжлагдаж байгаа 3,842.9 сая төгрөгийн 10 зээл;*
- *Гүйцэтгэх хуудас бичүүлэхээр хүлээгдэж байгаа 1,947.2 сая төгрөгийн 4 зээл;*
- *Нас барсан (өвлөгчөөс гаргуулна) 57.8 сая төгрөгийн 1 зээл;*
- *ШШГА-аа дуусгавар болсон-төлбөрт үл хөдлөх хөрөнгийг тооцон авсан 430.0 сая төгрөгийн 1 зээл*

1.8.7 Нийт зээлийн авлагын үлдэгдлээс хууль, хяналтын байгууллагад шилжүүлээгүй буюу ЖДҮГ-т ажиллагаа хийгдэж байгаа 4,865.4 сая төгрөгийн 214 зээлдэгчийн зээлийг эргэн төлүүлэх ажлыг эрчимжүүлж холбогдох арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв. *(Дэлгэрэнгүйг хавсралт 3-с үзнэ үү)*

1.8.8 ЖДҮХ сангийн муу зээлийн ангилалд байгаа 141 зээлдэгчийн 27,729.4 сая төгрөгийн эргэн төлүүлэх ажиллагаанд 269.9 сая төгрөгөөр зөвлөх үйлчилгээг авч ажиллуулснаар 2024 оны жилийн эцсийн байдлаар 366.1 сая төгрөгийн 7 зээлдэгчийн зээлийг төлүүлсэн байна.

1.8.9 Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар 7.2-т “Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн харьяа байгууллага, аж ахуйн нэгж өөрийн аппаратад дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлнэ” гэж заасан боловч уг хяналт шалгалтыг хийгээгүй байна.

1.8.10 УАГ-ын “ЖДҮХ сангийн үйл ажиллагааны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар ЖДҮГ-т нийт 9 зөвлөмж өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- *ЖДҮХ сангаас аймгуудад хуваарилах санхүүжилтийг төлөвлөхдөө өрсөлдөх чадвар, хүн амын тоо, ЖДҮҮ эрхлэгчдийн тоо зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан хуваарилах;*
- *ЖДҮГ-аас зээл хүсэгчдийн сан үүсгэн мэдээллийн цахим системийг боловсронгуй болгож, төслөөс санхүүжилт хүсэгч болон шалгарсан иргэн, ААН-ийн мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх боломжийг бүрдүүлэх;*
- *Зээлийн гэрээний дагуух эргэн төлөлтийн төлбөрийн чадварын үнэлгээ хийж, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналтыг тогтмол хэрэгжүүлэх;*
- *Төсөл хэрэгжүүлж байгаа ААН-үүдийн төслийн зориулалт, үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах замаар ЖДҮ эрхлэгчдийг хөгжихөд дэмжлэг үзүүлэх;*

1.8.11 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдээс ЖДҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, алдаа зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэв.

1.8.12 Аудитаар илэрсэн алдаа зөрчлөөс үзэхэд ЖДҮГ нь ЖДҮҮ эрхлэгч нарт сангаас олгох хөнгөлөлттэй зээлийг тэгш хүртээмжтэй олгож чадаагүй арилжааны банкнуудаар дамжуулан жижиг болон дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгч нарт хөнгөлөлттэй зээл олгоогүй. Үүнээс шалтгаалан сангийн хөрөнгийн эх үүсвэр бүрэн бүрдэхгүй байх, зээлийн эргэн төлөлт удаашрах нөхцөл үүсгэж байна.


ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын 2021 оны 394 дүгээр “Төрийн өмчит компани байгуулах тухай” тогтоолоор “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсан байна.

ТӨБЗГ-ын 2023 оны 505 дугаар “Хөрөнгө өр төлбөр балансаас балансад шилжүүлэх тухай” тогтоол, ХХААХҮ-ийн сайдын 2023 оны А/553 дугаар “Авлага, өр төлбөр балансаас балансад шилжүүлэх тухай” тушаал зэргийг үндэслэн Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албаны¹⁰ санхүүгийн тайланд бүртгэлтэй мөнгөн хөрөнгийн 13,419.2 сая төгрөг, авлагын 214,406.1 сая төгрөг, бараа материалын 35,632.3 сая төгрөг, үндсэн хөрөнгийн 81,296.4 сая төгрөг, богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн 257,027.3 сая төгрөгийг 2023 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөр тасалбар болгон “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-д бүрэн шилжүүлсэн байна.

Корпорацийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 19,974.9 сая төгрөг буюу өмнөх оноос 5.8 хувиар өссөн байна. Нийт хөрөнгийн 0.2 хувийг мөнгөн хөрөнгө, 49.1 хувийг авлага, 1.4 хувийг бараа, материал, 27.3 хувийг нөөцийн бараа, 21.9 хувийг үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна. Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн 27.2 хувийг богино хугацаат өр төлбөр, 46.8 хувийг урт хугацаат өр төлбөр, 26.0 хувийг төрийн өмч данс тус тус эзэлж байна.

“ХААК” ТӨХХК-ийн түүхэн замнал



“ХААК” ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 26 дугаар тогтоолоор “Бүтэц, орон тоог шинэчлэн батлах” орон тооны дээд хязгаарыг 121 байхаар тогтоосон үүнээс 119 албан хаагч ажиллаж байна.

“ХААК” ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 04 дүгээр “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах тухай” тогтоолын хавсралтаар орон нутаг дахь салбарыг дараах байдлаар баталсан байна. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь “Хөтөл” салбар
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум дахь “Сэлэнгэ” салбар
- Булган аймгийн Булган сум дахь “Булган” салбар
- Төв аймгийн Угталцайдам сум дахь “Угтаал” салбар
- Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь “Хархорин” салбар
- Дархан-Уул аймгийн Дархан сум дахь “Дархан” салбар
- Хэнтий аймгийн Өмнөдэлгээр сум дахь “Хурх” салбар (ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 27 дугаар тогтоолоор татан буулгасан)

¹⁰ ЗГ-ын 2020 оны 16 дугаар тогтоолоор “Мал хамгаалах сан” болон “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-г “хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын алба” болгож өөрчилсөн.

БҮЛЭГ 2. УЛААН БУУДАЙН БОЛОН БАГА ОВРЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ОЛГОСОН ДЭМЖЛЭГЭЭС 140,627.8 САЯ ТӨГРӨГ БУЮУ 80.4 ХУВЬ НЬ ГЭРЭЭНД ЗААСАН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

2.1 “ХААК” ТӨХХК-ийн ТУЗ бизнес төлөвлөгөөнд зорилтот түвшнийг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

2.1.1 Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн (цаашид ЗГТСтХ гэх) 5 дугаар зүйлийн 5.3.19-д заасан “Хөдөө аж ахуйг дэмжих сан” буюу ЗГ-ын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай төсвийн тусгай дансыг ЗГ-ын 2023 оны 269 дүгээр тогтоолоор татан буулгаж “ХААК” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу ашгийн төлөө хуулийн этгээд болгож өөрчилсөн байна.

2.1.2 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд “ХААК” ТӨХХК (ТБОНӨО) хувьцаа эзэмшигчээр “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам”-ыг бүртгэсэн байна.

2.1.3 “ХААК” ТӨХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд ХХААХҮЯ-аас 5 гишүүн, ТӨБЗГ-аас 1 гишүүн, хараат бус 3 гишүүн тус тус ажиллаж байна. Эдгээр нь Компанийн тухай хуулийн 75.1¹¹, 75.4¹², дүрмийн 9 дүгээр бүлэгт заасны дагуу шаардлага хангасан бүрэлдэхүүнтэй байна.

2.1.4 “ХААК” ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 24 дүгээр хурлын тогтоолоор “Стратеги төлөвлөгөө”-г баталсан байна. Стратеги төлөвлөгөөг 2023-2033 онд хэрэгжүүлэхээр алсын хараа, эрхэм зорилго үнэт зүйлс болон тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. “Монгол Улсын ХАА-н салбарын хөгжлийн түүчээлэгч төрийн өмчит компани болно” гэж алсын харааг тодорхойлон тэргүүлэх чиглэлийн дараах ажлуудыг хийхээр тусгасан байна. Үүнд:

- Байгууллагын засаглал, бүрэн эрхт байдлыг бэхжүүлэх;
- Байгууллагын нөөцийг чадавхжуулах, бэхжүүлэх;
- Байгууллагын санхүүгийн чадвар, хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулах;
- Шинжлэх ухаан, инновац болон судалгаанд суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх, нэмэгдүүлэх;
- Ажиллах хүчний хөгжилт, ажилтны нийгмийн хангамж, урамшууллын бодлого хэрэгжүүлэх;
- Байгууллагын хамтын ажиллагаа, харилцааг өргөжүүлэх, бэхжүүлэх гэх мэт

2.1.5 Стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийг ТУЗ-д 2 жил тутамд хэлэлцүүлэхээр заасан байна. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан тэргүүлэх чиглэлийн нэгдүгээр үе шатыг 2023-2028 он, хоёрдугаар үе шатыг 2028-2033 онд тус тус хэрэгжүүлэхээр 40 зорилтыг дэвшүүлсэн байна.

2.1.6 “ХААК” ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар 2023 оны бизнес төлөвлөгөөг, харин 2024 оны бизнес төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан боловч 9 дүгээр сарын 26-ны өдрийн 17 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Хүснэгт 14. Бизнес төлөвлөгөөний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 он			2024 он		
			Төлөв	Гүйц	Хувь	Төлөв	Гүйц	Хувь
1.	Улаан буудайн нөөц бүрдүүлэлт	Тонн	60,200.0	44,135.5	73.3	81,700.0	57,667.2	70.5
	Хүнсний улаан буудай	Тонн	55,200.0	28,775.4	52.1	73,700.0	49,528.5	67.2
	Үрийн буудай	Тонн	5,000.0	4,778.3	95.5	8,000.0	7,756.2	96.9
	Тэжээлийн буудай	Тонн		10,581.8			382.5	
2.	Авлага барагдуулалтын талаар	Сая.төг	8,668.8	16,183.1	186.7	39,635.0	42,354.0	106.8
3.	Зээл, санхүүгийн эргэн төлөлт	Сая.төг	20,800.0	26,600.0	127.9	26,336.9	7,711.2	29.2
4.	Байгууллагын орлого	Сая.төг	5,585.1	19,000.0	340.1	99,981.7	56,603.3	56.6
5.	Үйл ажиллагааны зардал	Сая.төг	9,131.1	6,435.9	67.8	103,333.8	66,418.2	62.4

¹¹ 75.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.

¹² 75.4.Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

	Үндсэн үйл ажиллагааны зардал	Сая.төг	9,036.0	6,400.0	70.8	99,533.8	64,312.9	64.6
	Хөрөнгө оруулалт	Сая.төг	101.1	35.9	35.5	3,800.0	2,105.3	55.4
	6.Бараа ажил үйлчилгээ худалдан авах	Сая.төг	3,469.1	2,103.3	60.6	6,862.2	1,794.5	26.1

Эх сурвалж: “ХААК” ТӨХХК

2.1.7 Санхүүгийн тайлангаар иргэн, ААН-ээс авах авлага 2023 онд 213,959.2 сая төгрөг 2024 онд 194,250.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсны 11.8 хувийг барагдуулахаар тооцсон нь үр дүнтэй төлөвлөлт болж чадаагүй байна.

2.1.8 Монгол Улсын стандарт хүнсний буудайн техникийн шаардлага MNS 0097:2010-д заасан соёолсон тариа зөөлөн буудайн физик химийн үзүүлэлт 2.0 хувь байхыг “ХААК” ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 15 дугаар тогтоол, гүйцэтгэх захирлын 2023 оны А/81 дүгээр “Хүлээн авах түр журамд өөрчлөлт оруулах чиглэл өгөх тухай” тушаалаар соёолсон тариан дээд хэмжээг 3,5 хувь болгон өөрчилж 151 ААН-ээс 5,967.8 сая төгрөгийн 6,486.7 тонн улаан буудайг хүлээн авсан байна.

2.1.9 “ХААК” ТӨХХК БНХАУ-ын ЗГ-ын дамжуулан зээл, БНБУ техникийн зээл, 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт үлдэгдэл 226,052.5 сая төгрөг, ханшийн зөрүүний гарз 50,223.7 сая төгрөг төлсөн байна.

Хүснэгт 15. “ХААК” ТӨХХК-ийн урт хугацаат зээлийн үлдэгдэл

№	Зээлийн эх үүсвэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний дугаар	Зээлийн дүн/сая.төг/	Ханшийн зөрүүний гарз	Зээлийн үлдэгдэл /сая.төг/
1	БНХАУ-ын ЗГ-ын дамжуулан зээл	2013.04.11	№7, Багц-1,2	USD 39.9	43,709.5	190,593.4
2	БНБУ-ын техникийн зээл	2021.08.31	210831/05-461/234	Euro 3.9	359.7	5,969.7
3	“Ди Би Эм лизинг”	2017.07.28	СТГ/17-01	USD 10.0	6,154.5	29,489.4
Нийт үлдэгдэл					50,223.7	226,052.5

Эх сурвалж: “ХААК” ТӨХХК

2.1.10 “ХААК” ТӨХХК-ийн ТУЗ-ийн “2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” 09 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөнд 36 арга хэмжээг 3,469.1 сая төгрөг төлөвлөснөөс 22 арга хэмжээнд 2,103.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 54 арга хэмжээнд 7,159.7 сая төгрөг төлөвлөснөөс 22 арга хэмжээнд 1,974.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 16. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

Бараа, ажил үйлчилгээний төрөл	2023 он				2024 он			
	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
	Ажлын тоо	Төсөвт өртөг	Ажлын тоо	Мөнгөн дүн	Ажлын тоо	Төсөвт өртөг	Ажлын тоо	Мөнгөн дүн
Бараа материал худалдан авах	4	1,675.6	4	1,126.5	25	4,854.1	12	1,126.4
Бусдаар ажил гүйцэтгүүлэх	27	1,193.5	15	518.1	27	2,165.6	9	768.3
Зөвлөх үйлчилгээ авах	5	600.0	3	458.7	2	140.0	1	80.0
Нийт	36	3,469.1	22	2,103.3	54	7,159.7	22	1,974.7

2.1.11 Худалдан авах ажиллагааны 2023, 2024 оны төлөвлөгөөнд нийтдээ 10,628.8 сая төгрөгөөр 90 ТАХ төлөвлөснөөс нээлттэй тендер шалгаруулалтаар 18 ТАХ, харьцуулалтын аргаар 45 ТАХ, шууд гэрээ байгуулах аргаар 29 ТАХ тусгаж баталсан байна. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт 17. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан хэлбэр

/сая.төг/

Он	Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан		Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын аргаар		Шууд гэрээ байгуулах	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2023	22	2,103.3	4	1,654.3	5	293.9	13	155.0
2024	22	1,974.7	6	1,372.6	7	49.4	9	552.7

2.1.12 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлээс харахад нийт 44 төсөл арга хэмжээний 10 буюу 22.7 хувийг нээлттэй тендер шалгаруулалт, 14 буюу 31.8 хувийг харьцуулалт, 22 буюу 45.5 хувийг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулсан байна.

2.1.13 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа “ХААК” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын “Үнэлгээний хороо байгуулах” тушаалаар 2023 онд 8, 2024 онд 26 үнэлгээний хороог байгуулсан байна.

2.1.14 Үнэлгээний хорооны сонгон шалгаруулсан худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг түүвэрлэн үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Худалдан авах ажиллагаанд оролцогчийн тендерийн баталгааны баримтыг хувийн хэрэгт бүрдүүлж оруулаагүй;
- Шалгарсан гүйцэтгэгч тендерийн баримт бичигт тусгасан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ ирүүлээгүй;
- Сүүлийн 3 жилийн дундаж нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ажил гүйцэтгэсэн мэдээлэл, жагсаалт гаргаж өгөөгүй;
- Худалдан авах ажиллагаанд оролцогчийн борлуулалтын орлогын мэдээлэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, харилцагч банкны мэдэгдлийг хувийн хэрэгт бүрдүүлж оруулаагүй;
- “ХААК” ТӨХХК-иас шалгарсан ААН-тэй байгуулсан бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээ болон гэрээ дүгнэсэн актыг архивын нэгжид хавсаргаагүй;
- Тендерийг хянан үзэх маягуудад Үнэлгээний хорооны дарга болон гишүүдийн өгсөн үнэлгээний тэмдэглэгээг хийгээгүй, гарын үсгээр баталгаажуулаагүй хэлбэрээр архивын нэгжийг бүрдүүлсэн.

2.1.15 Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйл 48.4-т “Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд 11 төрлийн баримт бичгийг хавсаргана” гэж заасныг зөрчсөн байна.

2.2 Хөдөө аж ахуйн чиглэлээр олгосон дэмжлэгийн 80.4 хувь нь гэрээний хугацаа хэтэрсэн байна.

2.2.1 Компанийн тухай хуулийн дагуу “ХААК” ТӨХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 2023 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 05 дугаар тогтоолоор 2023 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 25 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

2.2.2 “ХААК” ТӨХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 9 дүгээр тогтоолоор “2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталсан байна. Үүнийг ТУЗ-ийн 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 13 дугаар, 2024 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 17 дугаар тогтоолоор тус тус нэмэлт өөрчлөлт оруулан баталсан байна.

Хүснэгт 18. “ХААК” ТӨХХК-ийн Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

Он	Зорилтот түвшний төлөвлөгөө			Зорилтот түвшний гүйцэтгэл		
	Орлого	Зарлага	Ашиг /алдагдал	Орлого	Зарлага	Ашиг /алдагдал
2023	5,585.1	8,376.1	(2,791.0)	10,527.1	15,337.6	(4,810.4)
2024	99,981.7	99,801.4	180.3	56,603.3	64,312.9	(7,709.9)

2.2.3 2023, 2024 онд дараалан зорилтот түвшний эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт хангалтгүй нь дараах хүчин зүйлсээс шалтгаалсан байна.

Тухайлбал, 2023 онд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-д 2,500.0 сая төгрөгийн санхүүжилтийг буцаан төвлөрүүлсэн, 2023 онд худалдан авсан хүнсний улаан буудайн төлбөрт 4,600.0 сая төгрөгийг шилжүүлсэн, 2024 онд орлогын төлөвлөгөө 43.4 хувиар тасарсан нь дотоодын гурилын үйлдвэрүүдийн хүнсний улаан буудайн худалдан авалт буурсан, зардлын гүйцэтгэл 35.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь хүнсний улаан буудайн борлуулалт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс борлуулсан бүтээгдэхүүний өртөг буурсан зэрэг нь тус тус нөлөөлсөн байна.

2.3 Монголбанкны зээлийн мэдээллийн санд ХАА-н дэмжлэгээр олгосон зээлийн зарим мэдээллийг оруулаагүй байна.

2.3.1 “ХААК” ТӨХХК-ийн 2005 оноос хойш ХАА-н салбарыг дэмжихээр олгосон зээлийн мэдээллийг Монголбанкны ангиллын дагуу оруулсныг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт 19. Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй идэвхтэй зээлийн мэдээлэл (ангилал бүрээр)

/сая.төг/

Огноо	Зээлдэгчийн тоо	Зээл олгосон мөнгөн дүн	Зээлийн үлдэгдэл	Ангилал				
				Хэвийн (15-30 хоног)	Анхаарал хандуулах (90-аас бага хоног)	Хэвийн бус (91-180 хоног)	Эргэлзээтэй (181-360 хоног)	Муу (361-ээс дээш хоног)
2005	19	57.1	60.7					60.7
2007	1	166.0	58.6					58.6
2008	7	107.8	94.8					94.8
2009	44	1,185.9	834.6	23.0				811.5
2010	86	2,377.1	1,191.7	8.3	-			1,183.4
2011	85	6,497.3	7,932.1	-	-		16.9	7,915.1
2012	1570	11,356.4	7,749.6	980.2	-		-	6,769.4
2013	642	7,388.9	5,156.5	7.0	-		10.0	5,139.5
2014	2897	71,766.0	34,725.1	828.6	217.5	190.0	52.0	33,437.0
2015	1178	10,006.1	9,207.4	11.4	-	7.2	169.0	9,019.7
2016	664	4,170.5	3,943.7	83.8	-	46.5	-	3,813.3
2017	162	22,377.4	18,631.7	103.2	59.1	8.9	-	18,460.5
2018	166	3,149.8	3,024.7	70.8	-	11.0	2.4	2,940.5
2019	137	3,182.4	3,169.3	1,234.0	-	0.1	9.7	1,925.5
2020	35	2,668.4	2,579.9	156.4	66.2	-	29.6	2,327.7
2021	102	1,949.5	1,930.3	503.0	-	24.7	931.5	471.1
2022	103	9,263.1	8,851.2	5,823.1	25.0	73.3	2,915.8	13.9
Нийт	7898	157,669.8	109,141.7	9,832.7	367.9	361.7	4,136.9	94,442.4

Эх үүсвэр: “ХААК” ТӨХХК. Монголбанкны зээлийн мэдээллийн сан

2.3.2 Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2019 оны А-155, 134 тушаалын хавсралтаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1¹³-т заасан ангиллын дагуу 9,832.7 сая төгрөгийн 161 зээл хэвийн, 361.7 сая төгрөгийн 58 зээл хэвийн бус, 4,136.9 сая төгрөгийн 169 зээл эргэлзээтэй, 367.9 сая төгрөгийн 96 зээл хугацаа хэтэрсэн, 94,442.4 сая төгрөгийн 7394 зээл муу ангилалд бүртгэсэн байна.

2.3.3 Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгэгдсэн ангилал үнэн зөв эсэх нь тодорхойгүй, зээлийн ангиллын мэдээлэл зөрүүтэй, 65,844.8 сая төгрөгийн 654 улаан буудай болон бусад үйл ажиллагааг дэмжихээр олгосон зээлийн мэдээллийг бүртгээгүй байна. Аудитаар зээлдэгч нарын зээлийн мэдээллийг монгол банкны мэдээллийн санд бүрэн оруулж бүртгэх зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэв.

2.3.4 “ХААК” ТӨХХК-ийн Иргэн, ААН-ээс авах авлагыг тулган баталгаажуулахад 37 иргэн, ААН-д өгөх 12.3 сая төгрөгийн өглөгийг авлагаар бүртгэж тайлагнасан нь НББТХ-ийн 5

¹³ 2.1.1.1.Хэвийн, 2.1.1.2.Анхаарал хандуулах; 2.1.1.3.Чанаргүй ангилал, үүнээс; 2.1.1.3.а.Хэвийн бус; 2.1.1.3.б.Эргэлзээтэй; 2.1.1.3.в.Муу.

дугаар зүйлийн 5.1.4¹⁴, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5¹⁵ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

2.3.5 “ХААК” ТӨХХК-ийн нийт авлагын 1.7 хувь буюу 3,094.1 сая төгрөгийн 63 байгууллагын зээл дэмжлэгийн бус авлагад бүртгэлтэй байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 4-с үзнэ үү) Эдгээр байгууллагатай тооцоо нийлж, авлага барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

2.3.6 Аудитаар Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгээгүй 65,844.8 сая төгрөгийн 654 зээлдэгчдийн мэдээллийг бүртгүүлэх, ангиллыг үнэн зөв тогтоолгох, зөвлөмж хүргүүлэв.

2.4 ХАА-н дэмжлэг авсан 6387 зээлдэгч 78.7 хувь нь 6-аас дээш жилээр зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

2.4.1 ХАА-г дэмжихээр олгосон 174,986.5 сая төгрөгийн 8523 зээлээс 34,358.7 сая төгрөгийн 413 зээл хугацаандаа, 140,627.8 сая төгрөгийн 8110 зээл хугацаа хэтэрсэн байна.

Хүснэгт 20. ХАА-г дэмжих чиглэлээр олгосон хугацаа хэтэрсэн зээлүүдийн мэдээлэл

/сая.төг/			
№	Хугацаа хэтэрсэн жил	Зээлдэгчийн тоо	Мөнгөн дүн
1	1-2 жил	1223	43,707.9
2	3-5 жил	500	12,108.4
3	6-9 жил	1539	38,617.4
4	10-аас дээш жил	4848	46,194.1
Нийт		8110	140,627.8

Эх сурвалж: “ХААК” ТӨХХК

2.4.2 Эдгээрээс 3-аас дээш жилээр хугацаа хэтэрсэн зээлтэй 96,919.9 сая төгрөгийн 6887 зээлдэгч 68.9 хувийг эзэлж байгаа нь зээлийн авлагууд барагдахгүй байх эрсдэл үүсэж болзошгүй байна.

2.4.3 ХАА-н чиглэлээр олгосон үр буудай болон бага оврын тоног төхөөрөмжийн зээлийг 1014 иргэн, ААН-д 2-10 удаа олгосон байна.

Хүснэгт 21. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл (2-10 удаа)

/сая.төг/			
№	Зээл авсан тоо	Зээлдэгчийн тоо	Мөнгөн дүн
1	2-4	940	49,335.5
2	5-6	63	21,077.3
3	7-10	11	4,189.8
Нийт		1014	74,602.6

Эх сурвалж: “ХААК” ТӨХХК Санхүүгийн тайлан авлагын дэлгэрэнгүй

2.4.4 Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 21,077.3 сая төгрөгийн 63 зээлдэгчид 5-6 удаа зээл олгосон байгаа нь нийт хугацаа хэтэрсэн зээлийн 15 хувийг эзэлж байна. Холбогдох журам, дүрэмд ХАА-н дэмжлэг хүсэгчид ХХААХҮЯ-нд хамаарах тусгай сангаас хөнгөлөлттэй зээл, дэмжлэгийн үлдэгдэлтэй ААН-д дэмжлэг үзүүлэх эсэх талаар нарийн зохицуулалт байхгүйгээс шалтгаалаан хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өсөхөд нөлөөлж байна.

2.5 Хөөн хэлэлцэх хугацаа дууссан 8,425.0 сая төгрөгийн 94 зээлдэгчтэй 2024 онд шинээр гэрээ байгуулж хугацааг сэргээж ажилласан байна.

2.5.1 “ХААК” ТӨХХК нь 2023 онд нийт авлагын 3.9 хувь, 2024 онд 6.8 хувь буюу 48,303.8 сая төгрөгийн авлага төлж барагдуулахаар компанийн бизнесийн төлөвлөгөөнд тусгаж төлөвлөснөөс 58,537.1 сая төгрөгийн авлагыг төлүүлсэн байна. Мөн “ХААК” ТӨХХК-аас 2024 онд хуулийн хугацаа дууссан 8,425.0 сая төгрөгийн 94 зээлдэгчтэй шинээр гэрээ байгуулж хуулийн хугацааг сэргээх ажил хийгджээ.

¹⁴ 5.1.4-т “үнэн зөв байх,

¹⁵ 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”

2.5.2 Тус корпораци хугацаа хэтэрсэн зээлүүдийг эргэн төлүүлэхээр хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, хамтран ажиллаж байна. Тухайлбал,

- Шүүхийн шатанд 77 зээлийн 25,300.0 сая төгрөг;
- ШШГГ-шатанд 81 зээлийн 17,200.0 сая төгрөг;
- Цагдаа, АТГ-д шилжүүлсэн 2 зээлийн 612.8 сая төгрөг тус тус шалгагдаж байна.

2.5.3 “ХААК” ТӨХХК 2023, 2024 онуудад нэр бүхий өмгөөллийн нөхөрлөлтэй авлага барагдуулах ажиллагаа хийлгэхээр гэрээ байгуулж 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 3,950.8 сая төгрөгийн 549 зээлийн авлагыг барагдуулж ажилласан байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 22. Өмгөөллийн нөхөрлөлийн хариуцсан авлага, түүний гүйцэтгэл (2024 оны жилийн эцсийн байдлаар)

№	Өмгөөллийн нөхөрлөлийн нэр	Хариуцсан зээл		Гүйцэтгэл		Гэрээний мэдээлэл	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Авлага барагдуулсан мөнгөн дүн	Гэрээний байгуулсан он	Гэрээний дагуу олгосон мөнгөн дүн
1	Эм Жэй Эл атторнейс	613	22,145.7	152	1,260.8	2024	74.4
2	Хюмани дигнити	604	21,537.2	150	1,227.1	2023, 2024	218.6
3	Цэц партнерс	615	22,423.4	74	632.4	2024	38.2
4	Эн Ди Жи партнерс	617	21,588.1	173	830.5	2024	9.2
Нийт		2449	87,694.4	549	3,950.8		340.4

2.5.4 Зөвлөх үйлчилгээний гэрээнд хяналт тавьж, зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлж, ажиллах шаардлагатай байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.

Зээлийн батлан даалтын сангийн хуулийг УИХ-ын 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар баталсан. Уг хуульд заасны дагуу 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн үүсгэн байгуулагчдын анхны хуралдааныг СЗХ-ны дэд дарга бөгөөд орон тооны гишүүн, ЭЗХЯ-ны ХБСТЗГ-ын дарга, Хөдөлмөрийн яамны ЖДҮХ газрын дарга, Сангийн яамны СХААБГ-ын СБХ-ийн мэргэжилтэн, МАОЭНХ-ны дэд ерөнхийлөгч, МҮХАҮТ-ын Газрын дарга, Германы хамтын ажиллагааны олон улсын байгууллагын дэд дарга нарын бүрэлдэхүүнтэй зохион байгуулж Зээлийн батлан даалтын сан /цаашид ЗБДС гэх/-г байгуулсан байна.

Дүрслэл 4. ЗБДС-аас иргэн, ААН-д батлан даалт гаргах үйл явц



ЗБДС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 55,000.0 сая төгрөг, хөрөнгө оруулагч, хандивлагчдын оруулсан хөрөнгийн санхүүжилт 40.0 сая төгрөг, батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хураамжаас 4,960.0 сая төгрөгийг тус тус бүрдүүлж 14697 иргэн, ААН-ийн зээлд 580,386.4 сая төгрөгийн батлан даалт гаргасан байна.

Тус сангийн Удирдах зөвлөлийн 2024 оны 31 дүгээр тогтоолоор 66 орон тоотой ажиллагааг баталсны дагуу 52 ажилтантай, бүсчилсэн 4 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

ЗБДС-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3¹⁶, дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2-т заасны дагуу сангийн удирдах дээд байгууллага нь Удирдах зөвлөл бөгөөд тус Удирдах зөвлөл 9 гишүүнтэй, даргаар ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга ажиллаж байна. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд ЗБДС-ийн эцсийн өмчлөгч нь ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бүртгэлтэй байна. Тус сан нь 5 хувьцаа эзэмшигчтэй байна. Үүнд:

1. Сангийн яам
2. Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
3. Эдийн засгийн хөгжлийн яам /хуучин нэрээр/
4. Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
5. Хөдөлмөрийн яам /хуучин нэрээр/

¹⁶ 7.3. Сангийн удирдах дээд байгууллага нь Удирдах зөвлөл байх бөгөөд үүсгэн байгуулагчдын хурлаас Сангийн дүрэмд заасны дагуу Удирдах зөвлөлийн гишүүдийг томилно.

БҮЛЭГ 3. ЗБДС 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР 14,032 ЗЭЭЛДЭГЧИД 402,577.9 САЯ ТӨГРӨГИЙН ЗЭЭЛД БАТЛАН ДААЛТ ГАРГАСАН БАЙНА.

3.1 ЗБДС-ийн Удирдах зөвлөлийн баталсан зарим журмуудыг хууль зүйн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад хянуулаагүй байна.

3.1.1 ЗБДС-ийн зорилго нь барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, ЖДҮҮ эрхлэгчдийн үйл ажиллагаанд зээлийн батлан даалт гаргаж шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд оршдог байна.

3.1.2 ЗБДС-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, хуулийн этгээд, ЖДҮҮ эрхлэгчид зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус хуулийн этгээд байна.

3.1.3 УИХ-аас ЗБДС-ийн тухай хуулийг 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталж, хуульд дөрвөн удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

3.1.4 ЗБДС-ийн 6 дугаар зүйлийн 6.2¹⁷-т заасны дагуу 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн үүсгэн байгуулагчдын анхны хуралдаанаар ЗБДС-ийн дүрмийг баталсан байна.

3.1.5 ЗБДС-ийн дотоод үйл ажиллагааг зохицуулж буй Удирдах зөвлөлийн баталсан 16, Гүйцэтгэх захирлын баталсан 7 журам байна. Харин ЗБДС-ийн 11 дүгээр зүйлийн 11.1¹⁸-т “Удирдах зөвлөл Сангийн үйл ажиллагааны журмыг батална” гэж заасны дагуу дараах журмуудыг баталсан байна. Үүнд:

- “Зээлийн батлан даалтын сангийн батлан даалтын төрөл, хэмжээ, хугацаа, хураамж, шимтгэл, бусад нөхцөлийн журам” (2023 он)
- “Батлан даалт гаргах журам” (2024 он)
- “Батлан даалтаар хүлээсэн үүрэг гүйцэтгэх журам” (2024 он)
- “Батлан даалт гаргах үйл ажиллагааны хүрээнд банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах журам” (2013 он)
- “Сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах, байршуулах журам” (2024 он)
- “Бүртгэл, мэдээллийн хадгалалтын журам” (2018 он)

3.1.6 Дээрх журмуудыг ЗБДС-ийн 64 дүгээр зүйлийн 64.3¹⁹-т заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулаагүй байна.

3.2 ЗБДС-ийн нийт батлан даалтын 72.1 хувийг Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн батлан даалт эзэлж байна.

3.2.1 ЗБДС 2013-2024 оны хооронд үндсэн батлан даалт, Ипотекийн зээлийн батлан даалт, Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн батлан даалтад нийт 402,577.9 сая төгрөгийн 14032 зээлдэгчийн зээлийг батлан даасан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 23. Батлан даалгуулсан зээлдэгчийн тоо болон хөрөнгийн хэмжээ

/сая.төг/					
№	Төрөл	Зээлдэгчийн тоо	Зээлийн дүн	Батлан даалтын дүн	Хувь
1	Үндсэн батлан даалт	746	191,143.1	85,774.4	21.3
2	Ипотекийн зээлийн батлан даалт	1309	140,117.7	26,463.2	6.6
3	Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн батлан даалт	11977	394,496.8	290,340.3	72.1
Нийт		14032	725,757.6	402,577.9	100.0

Эх сурвалж: ЗБДС

¹⁷ Үүсгэн байгуулагчдын анхны хурлаар Сангийн дүрмийг батлах бөгөөд Сангийн дүрмийг баталснаар Санг үүсгэн байгуулсанд тооцно.
¹⁸ 11.1.Удирдах зөвлөл Сангийн үйл ажиллагааны дараах журмыг батална.
¹⁹ Энэ хуулийн 64.2-т зааснаас бусад захиргааны хэм хэмжээний актыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, бүртгэнэ.

3.2.2 УИХ-ын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн *Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар* ЗБДСТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1²⁰ дэх заалтыг нэмснээр 2024 онд Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн батлан даалтад нийт 290,340.3 сая төгрөг буюу нийт батлан даалтын 72.1 хувийг эзэлж байна.

3.2.3 Шинэ хоршоо хөдөлгөөний зээлд олгосон батлан даалтыг аймгуудаар нь хувьчлан үзвэл 95,985.4 сая төгрөг буюу 11 хувийг Архангай, Баянхонгор, Говь-Алтай, 61,508.1 сая төгрөг буюу 6-8 хувийг Төв, Увс, Хэнтий аймгууд эзэлж байна. */Дэлгэрэнгүйг хавсралт 5-с үзнэ үү/*

3.2.4 Батлан даалгуулсан зээлдэгчийн төрлөөс нь үзэхэд ЗБДС нь ХХААХҮЯ, зорилго, зорилтод бүрэн нийцэхгүй улсын хэмжээнд хамаарах зарим салбар буюу ипотека, шинэ хоршоо зэрэгт зээлийн батлан даалт гаргасан байна. Сангийн үйл ажиллагаанд СЗХ хяналт тавих чиг үүрэгтэй байна. ЗБДС-ын үйл ажиллагааны нэгдсэн бодлогоор хангах, дээд шатны байгууллагыг оновчтой тодорхойлж шилжүүлэх шаардлагатай байна.

3.2.5 ЗБДСТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.3-т²¹ заасны дагуу сангийн өөрийн хөрөнгөөр батлан даах нийт хэмжээг одоо байгаа эх үүсвэрээр тооцоолон үзэхэд 1.2 их наяд төгрөг хүртэл батлан даалт гаргах боломжтой байна.

3.3 ЗБДС-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-т сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр тусгасан ба нийт орлогын 91.5 хувийг хадгаламжийн хүүгийн орлого эзэлж байна.

3.3.1 ЗБДС-ийн нийт хөрөнгө бүрдүүлэлтийн 83.4 хувийг Хадгаламжийн даатгалын корпорацаас, улсын төсвөөс 8.3 хувь, хөрөнгө оруулагч, хандивлагчдаас 0.1 хувь, батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хураамжаас 8.2 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 24. Өөрийн хөрөнгийн бүрдүүлэлтийн байдал

				<i>/сая төгрөг/</i>	
№	Санхүүжилтийн эх үүсвэр	Олгосон санхүүжилт		Хувь	
1	Улсын төсвөөс	5,000.0		8.3	
2	Хадгаламжийн даатгалын корпорац	50,000.0		83.4	
2	Хөрөнгө оруулагч, хандивлагч	40.0		0.1	
3	Батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хураамж	4,960.0		8.2	
Өөрийн хөрөнгийн нийт дүн		60,000.0		100	

Эх үүсвэр: ЗБДС

3.3.2 Тус сан нь Хадгаламжийн даатгалын корпорацтай 2021 онд байгуулсан 12/02-02 дугаартай “Үнэт цаас худалдах, худалдан авах, түүнд батлан даалт гарган санхүүжүүлэх гэрээ”-нд заасны дагуу эргэн төлөлт хийж байна.

3.3.3 ЗБДС-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-т заасны дагуу 2023-2024 оны үйл ажиллагааны орлого дараах эх үүсвэрээс бүрдсэн байна.

Хүснэгт 25. ЗБДС-ийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

								<i>/сая төгрөг/</i>	
№	Үзүүлэлт	2023 он			2024 он				
		Төлөв.	Гүйц.	Хувь	Төлөв	Гүйц	Хувь		
1	Батлан даалтын шимтгэлийн орлого	787.4	864.2	109.7	5,600.0	6,675.6	119.2		
2	Хураамжийн орлого	11.4	9.8	86.1	20.0	21.6	108.3		
3	Хадгаламжийн хүүгийн орлого	10,384.8	10,934.2	105.3	21,437.1	19,839.4	92.5		
4	Үйл ажиллагааны бусад орлого	131.8	137.5	104.3	-	-	-		
Нийт дүн		11,315.3	11,945.7	105.6	27,057.1	26,536.6	98.1		

Эх сурвалж: ЗБДС

²⁰ 9.1. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх хоршооны гишүүн малчинд урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 100 хүртэлх хувьд батлан даалт гаргах.

²¹ 14.3. Сангаас гаргах батлан даалтын нийт хэмжээ нь Сангийн өөрийн хөрөнгийг 20 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

3.3.4 ЗБДС-ийн 2023 оны үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 11,315.3 сая төгрөг байсан ба бодит гүйцэтгэл 11,945.7 сая төгрөг буюу 5.6 хувиар давуулан биелүүлсэн байна. ЗБДС-ийн 2023-2024 оны нийт орлого хадгаламжийн хүүгийн орлого 91.5 хувийг хүүгийн орлого эзэлж байна.

3.4 СЗХ-ноос ЗБДС-ийн үйл ажиллагаанд 2023, 2024 онд хяналт, шалгалт хийгээгүй байна.

3.4.1 ЗБДС-аас эргэн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд олгосон батлан даалтууддаа түүвэрчлэн хяналт хэрэгжүүлдэг байна. 2023, 2024 онд 61,249.5 сая төгрөгийн 149 зээлд батлан даалт олгосон (*зээлийн үнийн дүн 96,376.9 сая төгрөг*) зээлүүдэд хяналт хэрэгжүүлж ажилласан байна. Энэ нь тухайн онуудад батлан даалт олгосон нийт зээлийн 14.6 хувийг эзэлж байна.

3.4.2 ЗБДС-тай холбоотой үйл ажиллагаа нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7²²-д заасны дагуу санхүүгийн үйлчилгээнд хамаардаг бөгөөд тус байгууллагад хяналт тавихтай холбоотой харилцааг СЗХ-ны 2019 оны 46 дугаартай “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг батлах тухай” тогтоолын хавсралтаар батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-аар зохицуулдаг.

3.4.3 Тус журмын 4 дүгээр зүйлийн 4.1²³, 4.2²⁴-д заасны дагуу сангийн үйл ажиллагааны хэрэгжилт хангагдаж байгаа эсэхэд газар дээрх хяналт, шалгалтыг жил бүр хийхээр журамласан боловч СЗХ-оос 2023, 2024 онд хяналт хэрэгжүүлээгүй байна. Цаашид журмын хэрэгжилтийг биелүүлж хяналт тавьж ажиллах шаардлагатай байна. Аудитаар зөвлөмж хүргүүлэв.

3.4.4 Харин ЗБДС-аас журмын 3 дугаар зүйлийн 3.1²⁵-т заасан тайлан, мэдээг СЗХ-нд тухай бүр тайлагнадаг байна. Энэхүү тайланд үндэслэн СЗХ нь улирал бүр сангийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг “Санхүүгийн салбарын тойм” байдлаар гаргаж олон нийтэд мэдээлдэг байна.

3.5 Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 665 зээлдэгчид 200,1 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна.

3.5.1 АХБ-ны санхүүжилттэй Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн хүрээнд 60.0 сая ам.долларын дамжуулан зээлийн гэрээг Сангийн яам, Зээлийн батлан даалтын сантай байгуулсан байна.

3.5.2 2017-2024 онд 665 зээлдэгчийн 323,307.4 сая төгрөгийн зээлд 200,138.7 сая төгрөгийн батлан даалт гаргасан байна.

²² 3.1. Энэ хуульд заасан санхүүгийн үйлчилгээнд дараах үйл ажиллагаа хамаарна: 3.1.7. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;

²³ 4.1. Сангийн үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилт хангагдаж байгаа эсэхэд газар дээрх хяналт, шалгалтыг Хорооноос хэрэгжүүлнэ.

²⁴ 4.2. Газар дээрх хяналт, шалгалт нь хамрах хүрээнээс хамаарч иж бүрэн болон хэсэгчилсэн байдлаар хийгдэнэ. Хорооны даргын томилсон ажлын хэсэг, баталсан удирдамжийн дагуу жил бүр газар дээрх хяналт шалгалтыг хийнэ.

²⁵ 3.1. Сан нь дараах тайлан, мэдээг заасан хугацаанд Хороонд хэвлэмлээр болон цахимаар ирүүлнэ: 3.1.1. батлан даалтын тайлан, батлан даалтын хөдөлгөөний тайлан, батлан даалтын ангиллын мэдээ, үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын мэдээг энэхүү журмын хавсралт 1, 2, 3, 4 дүгээр маягтын дагуу, мөн тайлант хугацаанд батлан даалтад хамрагдахаар, гаргасан хүсэлтийн тоог сар бүр гаргаж дараа сарын 10-ны өдрийн дотор; 3.1.2. энэ журмын 3.1.1.-т заасан мэдээ, тайлан, 5 дугаар хавсралтаар сангийн мөнгөн хөрөнгийг байршуулсан мэдээ болон Сангийн яамнаас баталсан маягтын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор; 3.1.3. Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасны дагуу санхүүгийн жилийн тайланд дараагийн санхүүгийн жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аудит хийлгэж, баталгаажуулсан санхүүгийн тайлан, дүгнэлт; 3.1.4. зайлшгүй шаардлагатай гэж үзсэн холбогдох мэдээ, тайланг тухай бүр;

Хүснэгт 26. АХБ-ны санхүүжилтээр 2017-2024 онд гаргасан батлан даалтын хэмжээ

Он	Зээлдэгчийн тоо	Зээлийн хэмжээ	Нийт батлан даалтын хэмжээ	/сая.төг/	
				АХБ-ны зээлийн хүүгийн төлбөрт төлсөн дүн	
2017	19	6,187.5	3,605.0		
2018	162	56,069.2	31,738.5		
2019	104	34,303.8	18,972.1	1,280.5	
2020	64	23,972.3	12,253.7	2,270.1	
2021	27	9,672.1	4,498.3	990.9	
2022	35	24,068.0	15,360.1	1,217.7	
2023	107	72,360.7	52,387.5	2,695.6	
2024	147	96,673.8	61,323.5	8,074.0	
Нийт	665	323,307.4	200,138.7	16,528.8	

Эх сурвалж: ЗБДС

3.5.3 Хүснэгтээс харахад 2023-2024 онд 113,711.0 сая төгрөгийн батлан даалт буюу нийт батлан даалт гаргасан дүнгийн 56.8 хувийг эзэлж байна. Үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг 2028 оноос төлж эхлэхээр байна.

Хүснэгт 27. Хадгаламжийн үлдэгдэлд бодогдсон хүү

Дансны нэр	2022 он		2023 он		2024 он	
	Хүү	Мөнгөн дүн	Хүү	Мөнгөн дүн	Хүү	Мөнгөн дүн
Дансны үлдэгдэлд бодогдсон хүү	10.5	5,625.8	13.5	4,562.2	15	4,325.9
Батлан даалтын үлдэгдэлд бодогдсон хүү	5	2,996.4	5	3,969.4	5	6,349.8
Нийт хүүгийн орлогын дүн		8,622.2		8,531.6		10,675.7

3.5.4 Хүснэгтээс дүгнэхэд АХБ-аас олгосон санхүүгийн эх үүсвэрийг ЗБДС-ийн нэр дээр Арилжааны банкны хадгаламжийн дансанд байршуулан дансны үлдэгдэл болон батлан даалтын үлдэгдлээс тус бүр хүүгийн орлого олдог байна.

3.5.5 АХБ-ны санхүүжилттэй зээлийн батлан даалтын үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 449 зээлдэгчийн 116,035.4 сая төгрөг байна.

Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Муу	Хэвийн бус	Эргэлзээтэй
406 зээлдэгч	17 зээлдэгч	23 зээлдэгч	1 зээлдэгч	2 зээлдэгч
108,706.7 сая төгрөг	4,223.9 сая төгрөг	2,578.3 сая төгрөг	250.4 сая төгрөг	276.2 сая төгрөг

3.5.6 Дээрх үзүүлэлтээс харахад нийт зээлийн үлдэгдлийн 108,706.7 сая төгрөг буюу 93.6 хувь нь хэвийн, 43 зээлдэгчийн 7,328.7 сая төгрөг буюу 6.4 хувь нь хугацаа хэтэрсэн, муу, хэвийн бус, эргэлзээтэй зээлийн ангилалд хамаарч байна. Тухайн чанаргүй зээлийг барагдуулахаар дараах ажиллагааг зохион байгуулж байна. Үүнд:

- ЗБДС нь арилжааны банкт хамтран 10 зээлдэгчийн 2,148.0 сая төгрөгийг
- Арилжааны банканд үүрэг гүйцэтгэснээс үүсэх авлагын гэрээний дагуу 11 зээлдэгчийн 963.9 сая төгрөгийн
- Шүүхийн ажиллагаанд 4 зээлдэгчийн 414.9 сая төгрөгийн
- Шүүхийн шийдвэр гарсан 6 зээлдэгчийн 820.9 сая төгрөгийн
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 5 зээлдэгчийн 496.6 сая төгрөгийг барагдуулахаар ажиллаж байна.

3.5.7 АХБ-ны санхүүжилттэй дамжуулан зээлээс батлан даалтын үлдэгдэлд хамаарах чанаргүй зээлийн ангиллын 15 зээлдэгчийн 1,732.4 сая төгрөгийг шүүхийн байгууллагад шилжүүлсэн байна.

3.5.8 Зээлийн батлан даалтын үйл ажиллагааг бусад улсад хэрэгжүүлдэг туршлагыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 28. БНСУ, Япон, Киргиз улсуудын ЗБДС-ийн үйл ажиллагааны талаар

Үзүүлэлт	Монгол Улс	БНСУ	Япон Улс	Киргиз Улс
Байгуулагдсан он	2012	1976	1950	2016
Удирдлагын хэлбэр	Төрийн өмчит сан	Төр болон хувийн хэвшлийн түншлэл	Төрийн агентлаг	Төр болон хувийн хэвшлийн түншлэл
Хэрэгжүүлэгч байгууллага	Зээлийн батлан даалтын сан	KODIT, KIBO	Japan Finance Corporation, CCGCs	Kyrgyz Guarantee Fund
Зорилго	ЖДҮҮ-ний зээлийн хүртээмж нэмэгдүүлэх	ЖДҮ, технологийн гарааны бизнесийг дэмжих	Инновац, ЖДҮҮ, хөдөө аж ахуйг дэмжих	ЖДҮҮ, бичил бизнес, хөдөө аж ахуйг дэмжих
Батлан даалтын хэмжээ /хувь/	60–100	85–100	~80	50–80
Батлан даалтын хугацаа	1–5 жил	3–10 жил	5–10 жил	1–5 жил
Батлан даалтын дээд дүн	1.2 тэрбум ₮ (≈ 350,000 USD)	3 тэрбум KRW (≈ 2.2 сая USD)	200 сая иен (≈ 1.3 сая USD)	10 сая KGS (≈ 115,000 USD)
Жилийн шимтгэл /хувь/	0.5–1.5	0.5–2	0.5–1.2	0.5–1.5

Эх сурвалж: ЗБДС, KODIT, JFC, KGF

3.5.9 Монгол Улсыг дээрх хөгжингүй улс орнуудтай харьцуулан үзэхэд батлан даалтын хэмжээ, хугацаа шимтгэлийн хувьд ойролцоо байна. Харин батлан даалт гаргах дээд хэмжээ, санхүүжилтийн төрөл аргуудыг өргөжүүлэх, технологи инновацад илүү анхаарах нь батлан даалтын сангийн цаашдын хөгжлийг түргэсгэх боломжтой. Мөн төр хувийн хэвшлийн түншлэл, олон улсын донор байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх нь санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны уян хатан байдлыг сайжруулахад чухал нөлөөтэй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

1. ЖДҮГ нь стратеги төлөвлөгөөгүй үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1²⁶, ЗГ-ын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.1²⁷ дэх заалтын дагуу ЖДҮГ нь стратеги төлөвлөгөө батлуулаагүй үйл ажиллагаа явуулж байна.
2. ЖДҮХ сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөлийг батлахдаа тухайн жилийн зээлийн хүү, үндсэн төлбөрөөс чөлөөлөх болон зээлийн хугацааг тогтоосон тооцоолол тодорхойгүй байна.
3. ХХААХҮ-ийн сайдын баталсан тухайн жилийн хөнгөлөлттэй зээл олгох салбар, чиглэлд тусгаагүй ангиллаар 25 ААН-д 2,828.9 сая төгрөгийн зээл олгосон нь ХХААХҮ-ийн сайдын 2023 оны А/37, 2024 оны А/28 дугаар “Хөнгөлөлттэй зээл олгох ерөнхий нөхцөл” баталсан тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
4. ХХААХҮЯ-ны дотоод хяналт шалгалтын газраас ЖДҮГ-ын үйл ажиллагаа, ЖДҮХС -аас хөнгөлөлттэй зээл авсан иргэн, ААН-н зээлийн эргэн төлөлтөд хяналт шалгалт хийгээгүй байна. Үүнээс шалтгаалж нийт зээлд эзлэх найдваргүй зээлдэгчийн тоо өссөн байна.

Жижиг, дунд үйлдвэрийн газар

1. ЗГ-ын 2020 оны 49 дүгээр “Агентлаг байгуулах тухай” тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийн газрыг байгуулж, ЖДҮХ сангийн ажлын албыг татан буулган, холбогдох чиг үүрэг, орон тоо, үйл ажиллагааны зардал, эд хөрөнгийн хамт уг газарт шилжүүлсэн байна
2. ЖДҮХ сангийн эх үүсвэрт 2023, 2024 онд нийт 111,677.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, бичил ангиллаар 74,043.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 545 ЖДҮҮ эрхлэгчдэд олгосон байна. Харин тус сангаас жижиг болон дунд үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгоогүй нь тэгш хүртээмжтэй зарчмыг баримталж ажиллаагүй байна.
3. Төсөл сонгон шалгаруулах хороо, дэд хороо болон нарийвчилсан үнэлгээ хийсэн ажлын хэсэг зарим төсөл сонгон шалгаруулах үе шат бүрд зээл хүсэгчээс ирүүлсэн баримт материалыг бүрэн нягтлан шалгаагүй, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх санхүүгийн чадамжийг бодитой үнэлээгүй байна. Төсөл сонгон шалгаруулах үнэлгээ хийх журамд төсөл хүлээн авснаас хойш үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, гэрээ байгуулах хугацааг тодорхой тусгаагүй байгаа нь хяналтын тогтолцоогүйг харуулж байна.
4. ЖДҮХ сангаас 2023, 2024 онд зарим ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгаагүй чиглэлээр 3,987.3 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 25 ААН-д олгосон нь сангийн үндсэн зорилгод нийцэхгүй байна.
5. ЖДҮХ сангаас 2009-2024 онд 370,110.2 сая төгрөгийн зээл олгосноос 50.3 хувь буюу 186,028.6 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. ЖДҮГ-аас авлагыг бууруулах талаар арга хэмжээ авч ажилласан ч үр дүн хангалтгүй байна.

²⁶ 53.1.Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

²⁷ 2.1. Стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд арга хэмжээний төлөвлөгөө батлагдсанаас хойш хоёр сарын дотор салбарын, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн, байгууллагын стратеги төлөвлөгөөг тус тус дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулна.

“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК

1. Засгийн газрын 2021 оны 394 дүгээр “Төрийн өмчит компани байгуулах тухай” тогтоолоор “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсан. ЗГ-ын 2023 оны 269 дүгээр Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албыг татан буулгаж “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-д шилжүүлсэн байна.
2. Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан улаан буудайн нөөц бүрдүүлэлт 2023 онд 73.3 хувь, 2024 онд 70.5 хувьтай төлөвлөгөө бүрэн биелэгдээгүй нь хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлэлт буурсан, элеваторын буюу нөөц савны багтаамжаас шалтгаалсан байна.
3. Санхүүгийн тайланд бүртгэлтэй иргэн, ААН-ээс авах авлага 2023 онд 213,959.2 сая төгрөг 2024 онд 194,250.3 сая төгрөг байгаагаас зөвхөн 11.8 хувийг нийт авлагыг барагдуулахаар төлөвлөсөн нь ажиллах хүчний нөөцөд уялдуулан төлөвлөөгүй байна.
4. “ХААК” ТӨХХК-ийн нийт өглөгийн үлдэгдэл 226,042.5 сая төгрөг байна. Үүнээс БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй дамжуулан зээлийн үлдэгдэл 190,593.4 сая төгрөг, БНБУ-ын техникийн зээлийн үлдэгдэл 5,969.7 сая төгрөг, “Ди Би Эм лизинг” ХХК-ийн санхүүгийн зээлийн үлдэгдэл 29,489.4 сая төгрөгийн зээлийг хуваарийн дагуу төлөлт хийгдэж байна.
5. “ХААК” ТӨХХК-ийн дэмжлэгийн бус зээлийн авлагад бүртгэлтэй байгаа 3,094.1 сая төгрөгийн 63 байгууллагатай тооцоо нийлж, авлага барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.
6. 2023, 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг хангалтгүй биелүүлж алдагдалтай ажилласан, ХАА-г дэмжихээр олгосон нийт 174,986.5 сая төгрөгийн 8523 зээлийн 80.4 хувь буюу 140,627.8 сая төгрөгийн 8110 зээл хугацаа хэтрэлттэй байна.
7. Монголбанкны зээлийн мэдээллийн санд ХАА-г дэмжих зээлийн 65,844.8 сая төгрөгийн 654 зээлдэгчийн мэдээллийг бүртгээгүй нь зээлийн эргэн төлөлтийг графикайн дагуу төлүүлэхгүй байх, нийт зээлд эзлэх муу зээлдэгчийн хувь хэмжээ нэмэгдэх эрсдэлтэй байна.

Зээлийн батлан даалтын сан

1. ЗБДС-ийн Удирдах зөвлөлийн баталсан зарим журмуудыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахгүйгээр үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.
2. УБЕГ-ын хуулийн этгээдийн улсын бүртгэлд ЗБДС-ийн хувьцаа эзэмшигчээр Сангийн яам, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Эдийн засгийн хөгжлийн яам /хуучин нэрээр/, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Хөдөлмөрийн яам /хуучин нэрээр/ бүртгэснийг шинэчлэх шаардлагатай байна.
3. ЗГ-ын 2021 оны 42 дугаар “Төлөвлөгөө батлах тухай” тогтоолд заасны дагуу ЗБДС нь Хадгаламжийн даатгалын корпораци хооронд байгуулсан 2021 оны 12/02-02 дугаартай “Үнэт цаас худалдах, худалдан авах, түүнд батлан даалт гарган санхүүжүүлэх гэрээ”-нд заасны дагуу санхүүжилтийн эргэн төлөлтийг хийсэн байна.
4. СЗХ-ны 2019 оны 46 дугаар “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журмыг батлах тухай” тогтоолын хавсралтаар батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2-т заасны дагуу ЗБДС-ийн үйл ажиллагааны хэрэгжилт хангагдаж байгаа эсэхэд 2023, 2024 онд хяналт, шалгалт хийгээгүй байна.
5. Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй дамжуулан зээлийн нийт үлдэгдэл 116,035.3 сая төгрөг байна. Үүнээс 43 зээлдэгчийн 7,328.7 сая төгрөг буюу 6.4 хувь нь чанаргүй зээлийн ангилалд бүртгэлтэй байна.
6. ХХААХҮЯ-ны харьяа ЗБДС нь салбарын яамны эрх асуудалд бүрэн нийцэхгүй салбарт зээлийн батлан даалт гаргаж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар /Монгол Улсын Ерөнхий сайд-д:

1. Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй уялдуулан бодлого арга зүйгээр хангах салбарын яамыг оновчтой тогтоож өгөх,

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц-д:

1. ЗБДС-ын үйл ажиллагаанд “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д заасны дагуу хяналт, шалгалтын тогтмол хийх

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн-д

1. ЖДҮГ-ын стратеги төлөвлөгөөг холбогдох хууль журамд нийцүүлэн боловсруулсан эсэхэд хяналт тавьж эрх бүхий албан тушаалтнаар батлуулах,
2. ЖДҮХ сангаас олгох хөнгөлөлттэй зээл олгох салбар чиглэлтэй уялдуулан, эдийн засгийн тооцоо судалгаа хийж ерөнхий нөхцөлийг батлах, хэрэгжилтэд хяналт хийх,
3. Хөнгөлөлттэй зээл авсан иргэн, ААН-ийн эргэн төлөлтөд үнэлгээ хийж, эрсдэлийг тооцож, хяналт шалгалт хийх.

Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан-д:

1. ЖДҮХ сангаас жижиг болон дунд ангиллын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкаар дамжуулан олгох нөхцөлийг бүрдүүлэх;
2. ЖДҮХ сангаас хөнгөлөлттэй зээл авахаар хүсэлт ирүүлсэн ААН-ийн төслийг тухайн жилийн ерөнхий нөхцөлд заасан салбар, чиглэлийн дагуу олгож байх;
3. “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулах (төсөл хүлээн авснаас хойш нарийвчилсан үнэлгээ хийх, сонгон шалгаруулалт хийх, гэрээ байгуулах үе шат бүрийн хугацааг тодорхой болгох);
4. Зээлийн авлагын үлдэгдлээс 214 зээлдэгчийн 4,865.4 сая төгрөгийн зээлийг эргэн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлж холбогдох арга хэмжээг авах;

“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Цогтсаран-д:

